



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Одонгийн ЦОГТГЭРЭЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-34-14, Факс: 32-30-34  
E-mail: tsogtgerelo@parliament.mn  
http://www.parliament.mn

2023.11.02 № ЗУХ-03/8652  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тов  
тогтоолгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд "ТУСГААР ТОГТНОЛ" Үндэсний баялгийн сангийн тухай анхдагч хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйл, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөл, холбогдох судалгаануудыг хавсаргав.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



О.ЦОГТГЭРЭЛ

2023000620

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 42 дугаар тэмдэглэлд:

“VIII.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн санаачлан боловсруулсан Тусгаар тогтнол Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн Тусгаар тогтнол Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах үндэслэлээр дэмжих боломжгүй гэсэн саналыг хуулийн төсөл санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2-т “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ” гэж, Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 1.1.2-т “Үндэсний баялгийн сан нь хөгжлийн болон хуримтлалын сан байх бөгөөд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын нөөц ашигласны төлбөр, төрийн өмчийн хувьцаа борлуулсны орлого, газрын тос, байгалийн хийн бүтээгдэхүүн хуваах гэрээний орлого, төрийн өмчийн хувьцааны ногдол ашиг, сангийн хөрөнгө оруулалтын цэвэр ашгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх”, 1.1.3-т “сангийн хөрөнгийн удирдлагын компани уг сангийн хөрөнгийн удирдлагыг хараат бусаар бие даан хэрэгжүүлэх, компанийн болон сангийн удирдлагын сайн засаглалыг хэвшүүлэх, сангийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг зохистой хэлбэрээр хэрэгжүүлэх бөгөөд сангийн хөрөнгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэддээ хүртээхдээ тэгш байдал, шударга ёсны зарчмыг дээдлэх, сангийн хөрөнгийн удирдлагын компанийн давуу эрхийн хувьцааны ногдол ашиг олгох” гэсэн чиглэлийг байгалийн баялгийн талаар боловсруулах хуулийн төсөлд тус тус баримтлахаар заасан.

Харин хуулийн төслийн үзэл баримтлалд сангийн хөрөнгийн эх үүсвэр нь зөвхөн улсын төсвөөс хамааралтай байхаар, хуулийн төсөлд “Тусгаар тогтнол Үндэсний баялгийн сан нь Төсвийн тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв сан, Иргэдийн өгөөжийн сан” байхаар зааж, сангуудын хөрөнгийн зарцуулалт одоогийн улсын төсвийн үндсэн зарцуулалтын чиг үүргээс ялгагдахгүй байхаар тусгасан нь Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон Үндэсний баялгийн санг бий болгох дээр дурдсан үзэл баримтлалд нийцээгүй байна.

Түүнчлэн төрийн өмчтэй холбоотой суурь харилцааг зохицуулах Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ын төсөл, Газрын

багц хуулийн төслийг баталсны дараа Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд болон дээрх хуультай нийцүүлэн энэхүү хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй байна.

2.Хуулийн төслийн зарим зүйл, хэсэг, заалт хоорондоо болон бусад хуультай нийцэхгүй, уялдаагүй, зөрчил үүсгэхээр байна. Хуулийн төслийн сангийн хөрөнгийн удирдлага, сангийн хөрөнгийн эх үүсвэр, зарцуулалт, хөрөнгө оруулалт, сангийн зарцуулалтын тайлагнал, ил тод байдлын талаарх зохицуулалт нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжтой уялдаагүй байх тул уг хуулийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах болон хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулах шаардлагыг хангаагүй, мөн хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг үзэл баримтлалд тусгаагүй байна.

Мөн хуулийн төслийн 10 дугаар зүйлд сангийн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгон шалгаруулах, сангийн хөрөнгийн мандатын төслийг боловсруулах, сангийн төсвийн төслийг боловсруулах, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах бүрэн эрхийг Төв банк /Монголбанк/ хэрэгжүүлэхээр тусгасан нь дээрх хуулийн зохицуулалттай нийцэхгүйгээс гадна Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд заасан Төв банк /Монголбанк/-ны үндсэн зорилт болон үйл ажиллагааны чиглэлтэй мөн нийцэхгүй болно.

Хуулийн төслийн 10.1.2-т сангийн хөрөнгийн удирдлагын мандатын төслийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр тусгасан нь Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27.1-д заасан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн чиг үүрэгт хамаарахгүй байна.


Түүнчлэн, хуулийн төслийн 12.3-т Сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд заасан хамаарах этгээдийг шууд тодорхойлсон нь төслийн 12.3.9-д “эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн 5-аас доошгүй хараат бус гишүүд,-ийг Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд байхаар, тус хараат бус гишүүдийг төслийн 10.1.1-д заасны дагуу Төв банк /Монголбанк/ сонгон шалгаруулахаар тусгасантай нийцэхгүй байна. Мөн Төв банк /Монголбанк/-ны нэр бүхий албан тушаалтнууд Удирдах зөвлөлийн дийлэнх хувийг дангаар бүрдүүлэхээр тусгасан бөгөөд хуулийн төслийн 5.1.6-д заасан сангийн үйл ажиллагаа нь улс төрийн нөлөөллөөс хараат бус байх зарчимтай нийцэхгүй, мөн засаглалын тэнцвэртэй харьцаа алдагдах нөхцөл үүсэж болзошгүй байна.

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 13.3-т “Сангийн хөрөнгийн удирдлагыг энэ хуулийн дагуу байгуулагдах Корпораци хэрэгжүүлнэ.” гэж, мөн хуулийн 18.1-д “Корпорацийг үүсгэн байгуулах, татан буулгах шийдвэрийг Засгийн газар гаргаж, Улсын Их Хуралд танилцуулна.” гэж тус тус заасан бөгөөд Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 303 дугаар тогтоолоор “Ирээдүйн өв сан корпораци”-г байгуулан үйл ажиллагаа явуулж байна. Харин хуулийн төслийн үзэл баримтлалд сангийн хөрөнгө, үйл ажиллагааны хувьд эзэн этгээд буюу эрх зүйн харилцааны субъект байгаагүй гэж зөрүүтэй мэдээлэл тусгаж, тодорхойлсныг анхаарах шаардлагатай байна.

3.Хуулийн төсөлд тусгасан зарим зохицуулалтын эрх хэмжээ, чиг үүрэг, үйл ажиллагааг явуулах зардлын хэмжээ зэрэг нь тодорхойгүй байна. Тухайлбал, хуулийн төслийн 14.2.3, 16.3-т “Тэтгэврийн нөөц сан”-ийн талаар тусгасан бөгөөд тус санг байгуулах, сангийн орлого, зарцуулалт, бусад зохицуулалтуудыг аль хуулиар, хэрхэн зохицуулах нь тодорхойгүй байна. Мөн хуулийн төслийн 16.4.1-д “Сангийн орлогын 50 хувийг жил бүр Монгол Улсын 18-аас дээш насны иргэн бүрд үндэсний баялгийн үр өгөөжийг олгож, өрхийн санхүүгийн чадавхыг дэмжихэд зарцуулна.” гэж заасан бөгөөд үндэсний баялгийн үр өгөөжийг олгохдоо ямар нөхцөл, шалгуураар хэрхэн олгох нь тодорхойгүй байхаас гадна Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэж заасантай нийцсэн эсэхийг нягтлах шаардлагатай байна.

Мөн хуулийн төслийн 18.3-т “Стратегийн хэрэгжилтэд Удирдах зөвлөл түүний дэргэдэх Аудитын хороогоор дамжуулан байнгын хяналт тавьж ажиллана.” гэж заасан бөгөөд тус аудитын хорооны бүрэлдэхүүн, чиг үүрэг, ажиллах журам, корпорацийн үйл ажиллагаа, хөрөнгийн удирдлагатай холбоотой зардал болон аудитын байгууллагаар аудит хийлгэх зардал тодорхойгүй байна.

4.Хууль тогтоомжийн тухай хуулийн 33.3-т “Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад хуулийн төсөл болон дагаж гарах хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрд дараах мэдээллийг агуулсан тайлбарыг тусгана” гэж, мөн зүйлийн 33.4-т “Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад энэ хуулийн 33.3-т заасан тайлбарыг шинэчилсэн найруулга бол бүлгээр, нэмэлт, өөрчлөлт бол зүйл, эсхүл хэсэг, заалт тус бүрээр багцлан тусгана” гэж тус тус заасны дагуу Тусгаар тогтнол Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг бэлтгээгүй, Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д заасны дагуу бусад бүрдүүлбэрийг бүрэн хангаж боловсруулаагүй байна.” гэжээ.



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**



**БАТЛАВ:**

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**



**О.ЦОГТГЭРЭЛ**

**“ТУСГААР ТОГТНОЛ ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ”  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Монгол улс 2007 онд “Монгол улсыг хөгжүүлэх сан”, 2009 онд “Хүний хөгжил сан” байгуулж байгалийн нөөцийн орлогыг тусгай санд төвлөрүүлж удирдах оролдлогууд хийсэн. 2010 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 2016 онд Ирээдүйн өв сангийн тухай хууль батлагдсанаар олон улсын жишигт нийцэх Үндэсний баялгийн сангийн эрхзүйн орчин бүрдсэн. Харамсалтай нь, дээрх сангууд төсвийн хавсарга төдий байж нийгмийн шинжтэй халамжийн шинжтэй арга хэмжээнүүд санхүүжүүлснээр өмнөө тавьсан үүргээ гүйцэтгэж чадсангүй. Дээрх сангуудын их наядаар хэмжигдэх хөрөнгө мөнгө ердөө улс төрчдийн амлалтыг биелүүлдэг хэрэгсэл болж хувирсан. Үүнд манай улсад байгуулагдсан сангууд төрийн байгууллагын эсвэл төрийн өмчит компани хэлбэрийн статустай байсан нь нөлөөлжээ. Иймээс нээлттэй хувьцаат компани, хувийн хөрөнгө оруулалтын компани хэлбэртэй зохион байгуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Тиймээс үндэсний баялгийн сангийн эрх зүйн зохицуулалтын бодит зүй тогтол, чиг хандлагыг баримжаалсан, өөрийн орны хөгжлийн зорилгод нийцсэн төдийгүй Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлж чадахуйц зорилго, зохицуулалт бүхий Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах зайлшгүй шаардлагатай байна.

### **1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж заасан байдаг.

Мөн Үндэсний баялгийн сангийн төрөл, түүний эрх зүйн орчныг бүрдүүлэхтэй холбоотойгоор Монгол Улсын Их Хурал 2020 оны 2 дугаар тогтоол, 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, 2020 оны 24 дүгээр тогтоолоор “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2021 оны 12 дугаар тогтоолоор “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” зэргийг тус тус үндэслэн боловсруулсан болно.

## 1.2. Практик шаардлага

Дэлхийн банкны “Уул уурхай ба оюун ухаан: Байгалийн баялгийн өгөөжийг институт болон хүний хөгжилд чиглүүлэх нь” товхимолд “өнгөрсөн 20 жилийн туршид монгол Улс уул уурхайгаас олсон орлогын 1 ам.доллар бүрийн 99 центийг хэрэглэж, дөнгөж нэг центийг л хуримтлуулжээ. Уул уурхайн салбар 2004 онд эрчимжиж эхэлснээс хойших хугацаанд Монгол Улс нийт 28 тэрбум ам.долларын уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ. Энэ орлогыг 3 ангилж болно; үүнд цалин, ашиг, татвар болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр багтана. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс гадна Засгийн газар ирээдүйн ашигт малтмалын орлогоо барьцаалан 8.7 тэрбум ам.долларын зээл аваад байна. Засгийн газар 2011 оноос Тогтворжуулалтын сан, ирээдүйн өв санд хуримтлуулж эхэлснээр сүүлийн 9 жилд энэ хоёр санд 1.4 тэрбум ам.доллартой тэнцэх хуримтлал орж, 1.2 тэрбум ам.долларын зарцуулалт гарснаар цэвэр дүнгээр 0.2 тэрбум ам.долларын үлдэгдэлтэй байна.

Товчхондоо Монгол Улс уул уурхайн орлогоо бараг бүгдийг нь зарцуулжээ” хэмээн тун тодорхойгоор өгүүлсэн байдаг. Нүүрс, зэс тэргүүтэй уул уурхайн олон томоохон уурхай үйл ажиллагаагаа явуулж, Монгол улсын уул уурхай, эрдэс баялгийн салбар нэгдсэн төсвийн 1/3, нийт экспортын 90 гаруй бүрдүүлэх эдийн засгийн голлох салбар болон хөгжиж байна.

Эдийн засаг дах эрдэс баялгийн салбарын нөлөө өсөхийн хэрээр Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг газруудын мэдээлж байгаагаар Монголын нийт хүн амын 1/3 нь ядуу, нэн ядуу түвшинд хүрч, ядуурал улам бүр гүнзгийрч байна. Энэ нь уул уурхайгаас олсон мөнгөө зөв зохистой зарцуулж чадахгүй, ирээдүйд зориулан хуримтлал үүсгэхгүйгээр төсвийн алдагдлыг нөхөх, эрх баригчдын сонгуулийн амлалтыг биелүүлэх бэлэн мөнгөний “касс” болгон ашиглаж буйтай холбоотой юм. Түүгээр ч зогсохгүй уул уурхайн салбараас орох ирээдүйн орлогоо барьцаалан зээл аван, халамж болгон тарааж хойч үедээ өр өвлүүлж байсан муу түүх ч бий.

Монгол Улсын Үндсэн хуульд үндэсний баялгийн сангийн эх санаа, зарчим тусгагдсаны зэрэгцээ үндэсний баялгийн сангийн нэг төрөл болох хуримтлалын сан (Ирээдүйн өв сан), түүний эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль үйлчилж байна. Мөн үндэсний баялгийн сан нь тодорхой төрлүүд (“хуримтлалын” болон “хөгжлийн”)-тэй байж болохыг тодорхойлжээ. Харин газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг төвлөрүүлж, улмаар арвижуулж, тэгш шударга хүртээх зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэг гол оролцогч болох хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх сан буюу Хөгжлийн сан, түүний эрх зүйн байдлыг тогтоосон хууль байхгүй байна.

Тиймээс үндэсний баялгийн сангийн нэгэн төрөл болох хөгжлийн сангийн эрх зүйн байдлыг тогтоосон хуулийн төслийг боловсруулан батлах хэрэгцээ, шаардлага гарцаагүй бий болсныг дахин онцолж байна.

**Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

“Үндэсний баялгийн сангийн тухай” хуулийн төсөл нь 7 бүлэг 28 зүйлтэй байх бөгөөд төсөлд дараах асуудлыг тусгасан болно.

Хуулийн төслийн:

➤ Нэгдүгээр бүлгээр нийтлэг үндэслэл буюу энэ хуулийн зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, Баялгийн сангийн хөрөнгийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, Баялгийн сангийн төрлийн талаар;

➤ Хоёрдугаар бүлэгт баялгийн сангийн эх үүсвэр, төрөл, зарцуулалтын талаар;

➤ Гуравдугаар бүлэгт баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын талаар;

➤ Дөрөвдүгээр бүлэгт Үндэсний баялгийн сангийн корпораци, түүний үйл ажиллагааны талаар;

➤ Тавдугаар бүлэгт баялгийн сангийн засаглалын талаар;

➤ Зургаадугаар бүлэг баялгийн сангийн тайлагнал, ил тод байдал, хяналтын талаар;

➤ Долоодугаар бүлэг бусад зүйл буюу хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацааны талаар тус тус зохицуулсан.

Газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг хуримтлуулж, дотоод, гадаадын хөтөлбөрүүдэд санхүүгийн үр ашигтай хөрөнгө оруулалт хийх замаар хөрөнгийг арвижуулах Корпораци хэлбэрээр байгуулах бөгөөд Монгол Улсын Засгийн газар нь хувьцаа эзэмшигч байна. Төлөөлөн Удирдах Зөвлөл нь сангийн хөрөнгийн удирдлагын мандат боловсруулах, ногдол ашгийн бодлогыг тодорхойлох, сангийн гүйцэтгэх удирдлагыг сонгож томилох эрхтэй. Тус сангийн гүйцэтгэх удирдлага нь мэргэжлийн баг байна.

Манай улс баялгийн менежментийн цэгцтэй, тууштай бодлогогүй явж ирсний уршгаар байгалийн баялгийн өгөөжийг хангалттай хүртэж чадахгүй, хойч үедээ үлдээх өвгүй, улс орныхоо хөгжлийг тэтгэх чадваргүй байна. Олон арван их наядын хөрөнгөтэй хэдий ч эдийн засгийн үр өгөөж муутай, төрийн нэртэй улс төрийн намын өмч эдийн засагт давамгайлж, хувийн хэвшлийн хөгжил, чөлөөт зах зээлийг боомилон авлига гаарч улмаар ардчилалд аюул занал учруулах боллоо.

Тийм ч учраас Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс өнгөрснөө дүгнэж, хөгжлийн боломжоо бүрэн ашиглахын тулд Тусгаар тогтнол Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан өргөн барьж байна.

Тус хуулийн төсөл олон улсын шилдэг туршлага, засаглалын зарчмуудыг судалж нэвтрүүлэхийн тэргүүн зорилтоо болголоо.

Хуулийн төсөлд дараах суурь зарчмуудыг чухалчлан тусгаад байна. Үүнд:

1. Баялгийн сан улс төрөөс ангид байх болно.

2. Баялгийн сан халамжийн сан биш болно.

3. Баялгийн сан өнөө ба ирээдүйн иргэн бүрд зориулагдана.

4. Баялгийн сан улсын төсвийн далд халаас биш болно.

5. Баялгийн сан Төрийн өмчит компаниудаас биш харин уул уурхайн салбараас бүрддэг болно гэсэн зарчмууд мөрдөгдөж эхэлнэ.

Нөхөн сэргэдэггүй байгалийн нөөц баялагтай улс орны өмнө боломж ба сорилт тулгардаг. Хэрвээ зөв ашиглавал эдгээр баялаг нь одоо болон ирээдүй үеийнхэнд

хөгжил, цэцэглэлт авчирна, харин буруу ашиглах буюу үрэн таран хийвэл эдийн засгийн тогтворгүй байдал, нийгмийн зөрчилдөөн, хүрээлэн буй орчны үргэлжилсэн доройтолд хүргэж болно. Байгалийн баялаг нь дахин сэргэдэггүй баялагт хамаарах тул ашиглах тусам баялгийн хэмжээ багасна.

Иймээс баялгийг ашиглах цаг хугацаанд үр өгөөж нь түүнтэй адил эсхүл түүнээс илүү байх ёстой. Монгол Улс нь байгалийн баялагт түшиглэсэн эдийн засаг бүхий улсын хувьд баялгаа урт хугацааны хөгжлийн бодлого, улсын онцлог, нийгмийн тулгамдсан асуудал зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзэж ард түмэндээ тэгш, шударга хүртээх суурь зарчмыг баримтлах нь зөв байна.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Байгалийн баялгаас олсон орлогыг хуримтлуулан, тодорхой зорилгоор зарцуулалт, хуваарилалт хийхийн тулд сангийн хөрөнгийг арвижуулах төсөл, хөтөлбөр санхүүжүүлэхэд зарцуулах хууль эрхзүйн үндэс тавигдана.

Дээрх сангуудын бүтэц, зохион байгуулалт, засаглал, үйл ажиллагаанд дараах нийтлэг дутагдлууд арилна. Үүнд:

- Сангийн хөрөнгийн эх үүсвэр зөвхөн улсын төсвөөс хамааралтай байсан тул Төсөв №2 байсаар ирсэн.

- Сангийн хөрөнгө, үйл ажиллагааны хувьд эзэн этгээд буюу эрх зүйн харилцааны субъект байгаагүй.

- Сангийн засаглал буюу найдвартай тогтолцоо, мэргэжлийн баг байгаагүй.

- Сангийн хөрөнгийг захиран зарцуулах үйл ажиллагаанд тавих хяналт сул байсан.

- Улс төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд өртөгдсөөр иржээ. Өөрөөр хэлбэл, сонгуультай холбоотойгоор бэлэн мөнгө тарааж байсны улмаас сангийн хөрөнгө шавхагдсан зэрэг болно.

Байгалийн баялгийг оновчтой зөв удирдах, тэгш хуваарилах, эдийн засгийн уналт, өсөлтөөс урьдчилан сэргийлэх хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд дэлхийн улс орнууд үндэсний баялгийн санг тэр дундаа түүний нэг төрөл болох хөгжлийн санг байгуулна.

**Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал**

Тусгаар тогтнол Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомжтой нийцэж байгаа болно. Хуулийн төсөлтэй холбогдуулан Ирээдүй өв сангийн тухай хуулийг хүчингүй болгож, Төвбанк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг төслүүдийг дагалдуулан боловсрууллаа.



## **ТУСГААР ТОГТНОЛ ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Манай улс баялгийн менежментийн цэгцтэй, тууштай бодлогогүй явж ирсэний уршгаар байгалийн баялгийнхаа өгөөжийг хангалттай хүртэж чадахгүй, хойч үедээ үлдээх өвгүй, улс орныхоо хөгжлийг тэтгэх чадваргүй байна. Олон арван их наядын хөрөнгөтэй хэдий ч эдийн засгийн үр өгөөж муутай, төрийн нэртэй намын өмч эдийн засагт давамгайлж, хувийн хэвшлийн хөгжил, чөлөөт зах зээлийг боомилон авилга гаарч улмаар ардчилалд аюул занал учруулах боллоо.

Тус хуулийн төсөл олон улсын шилдэг туршлага, засаглалын зарчмуудыг судалж нэвтрүүлэхийн тэргүүн зорилтоо болголоо. Хуулийн төсөлд дараах суурь зарчмуудыг чухалчлан тусгаад байна. Үүнд:

### **БАЯЛГИЙН САН УЛС ТӨРӨӨС АНГИД БАЙХ ЁСТОЙ**

Сүүлийн 15 жилийн хугацаанд Монгол Улс 30 орчим тэрбум ам.долларын уул уурхайн бүтээгдэхүүн олборлон гаргасан ч олсон орлогынхоо 100 төгрөг тутмын ердөө 1 төгрөгийг нь хуримтлуулж үлдсэн 99 төгрөгийг үрж дуусгажээ. Үр дүнд нь нийгэм, эдийн засгийн хөгжилд чанарын ахиц гарсангүй, байгаль орчин доройтлоо. Үүний гол шалтгаан бол улс төрийн популизм, түүний ард нуугдаж нийтийн баялагт эзэн суух сонирхолтой авилгач ангийн үйл ажиллагаа юм.

Иймд эрдэс баялгийн орлогыг сонгуулиас сонгуулийн хооронд улс төрчдийн үзэмжээр зарцуулдаг явдлыг таслан зогсоож Үндэсний баялгийн санг жинхэнэ утгаар нь байгуулан Монгол Улсын урт хугацааны эдийн засгийн хөгжил, хүн амын хангалуун амьдралын баталгаа болгох ёстой. Үүний тулд Баялгийн санг хараат бусаар, тогтвортой ажиллуулах хууль эрхзүйн үндэслэл тавигдаж байна.

### **БАЯЛГИЙН САН БОЛ ХАЛАМЖИЙН САН БИШ**

Нийгмийн хамгааллын бодлого нь баялгийн сангаас тусдаа Засгийн газрын чиг үүрэгт хамаарах асуудал юм. Өнгөрсөн 15 жилд улсын төсөвт уул уурхайн салбараас 10 тэрбум гаруй ам.долларын орлого орсон, түүнийгээ барьцаалж мөн 10 шахам тэрбум ам.долларын зээл авч зарцуулжээ. 2012-2016 онуудад хийгдсэн аж үйлдвэр, дэд бүтцийн хөрөнгө оруулалтуудыг эс тооцвол дээрх мөнгө үндсэндээ нийгмийн халамжид зориулагдсан. Гэвч ядуурал буурсангүй, орлогын тэгш бус байдал гүнзгийрчээ.

Бодит байдал ийм байтал баялгийн сан дахин халамж тараадаг, иргэдэд аливаа хэлбэрээр бэлэн мөнгө олгодог болох аваас хуримтлуулдаг биш тараадаг, хуваадаг сан болохоос сэргийлж байна.

Харин гадаад зах зээлд урт хугацааны, эрсдэл багатай хөрөнгө оруулалт хийдэг, дотоод зах зээлд улс орны тогтвортой хөгжлийг дэмжих стратегийн хөрөнгө оруулалт хийдэг баялгийн сангийн оновчтой хувилбарыг сонгосон болно.

### **БАЯЛГИЙН САН ӨНӨӨ БА ИРЭЭДҮЙН ИРГЭН БҮРТ ЗОРИУЛАГДНА**

“Эх орон, газар нутгаа бид өвөг дээдсээсээ хүлээж авсан, үр хойчдоо өвлүүлж өгнө” гэдэг алтан зарчим нөхөн сэргээгддэггүй байгалийн нөөц баялгаа ашиглах бидний бодлогын үндэс байх учиртай. Ирээдүйн өв сан, Төсвийн тогтворжуулалтын сангуудыг олон улсын жишигт нийцүүлэн хуульчилсан ч эрх баригч улс төрийн хүчний шийдвэрээр уг сангуудийн хөрөнгийг улс төрийн амлалтад зарцуулж, хойч үеийнхнийхээ өвийг

өнөөдөр идэж дуусгаж байна. Сүүлийн жилүүдэд төсвийн хэт үрэлгэн бодлого явуулаагүй бол дээрх сангуудад багадаа 9 их наяд төгрөгийн хуримтлал бий болсон байх боломжтой байв. Гэтэл бодит үлдэгдэл үүний 10 хувьд ч хүрэхгүй болжээ.

Шинээр байгуулах Үндэсний баялгын сан нь Монгол Улсын Үндсэн Хуульд тунхагласан дагуу одоо ба ирээдүй үеийн иргэн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулж баялгийн үр өгөөжийг тэгш, шударга хүртээх тогтолцоог бий болгоно.

### **БАЯЛГИЙН САН ТӨСВИЙН ДАЛД ХАЛААС БАЙЖ БОЛОХГҮЙ**

Баялгийн сангийн хөрөнгийг улсын төсвийн хөрөнгө оруулалт, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийгдэх боломжтой төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулж болохгүй. Хэрэв Засгийн газрын элдэв сүржин нэртэй богино хугацааны зорилтуудыг хэрэгжүүлээд эхэлбэл Баялгийн сан нийт иргэдийн төлөөлөл болох парламентын хяналтаас гадуур дараагийн далд төсөв болох эрсдэлтэй. Ингэвэл өнөөдөр үүсээд байгаа төрийн өмчит уул уурхайн компаниуд, Хөгжлийн банк зэргээр дамжуулан төсвийн гадуур түүнээс ч их хөрөнгийг хяналтгүй зарцуулж буй явдал улам томорч авилга, албан тушаалын хэрэг даамжирна. Иймд Баялгийн сангийн хөрөнгө оруулалтын мандат, бодлогын баримт бичгийг нарийн төлөвлөн баталж шийдвэр гаргах болон хяналтын тогтолцоог Засгийн газрын оролцоогүй, сайд нарын эрх мэдлээс дээгүүр байхаар хуульд тусгаад байна.

### **БАЯЛГИЙН САНГ ТӨК-ИУДААС БИШ УУЛ УУРХАЙН САЛБАРААС БҮРДҮҮЛНЭ**

Баялгийн өгөөжийг иргэн бүрт хүртээх асуудлыг нийгэмчлэлтэй холбож тайлбарлах явдал хэрээс хэтэрлээ. Уул уурхайн салбарыг бүхэлд нь төр эзэмшиж байж иргэдэд өгөөжөө өгдөг мэтээр сурталдаж, улмаар төрийн нэрээр улс төр, эдийн засгийн ашиг сонирхол бүхий бүлэглэлүүд байгалийн баялгийг эзэгнэн нийгэм улам бүр авилгажиж байна. Төрийн өмчийн компаниуд томрохын хэрээр баялаг бүтээгчид биш харин эрх баригчдыг тойрсон этгээдүүд л хөрөнгөжиж бизнесийн орчин доройтон чөлөөт зах зээл төрийн капитализмд шахагдаж байна.

Төрийн өмчийн, асар их хөрөнгөтэй ч үр ашиг муутай ажилладаг уул уурхайн компаниудыг нээлттэй, олон нийтийн компани болгож хувийн хэвшлийн сайн менежментээр ажиллуулан дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг оролцуулж өөрчлөн зохион байгуулах нь урт хугацаанд улс орны хөгжлийг тэтгэх тулгуур болно. Иргэд эндээс үнэ төлбөргүйгээр давуу эрхийн хувьцаа эзэмших замаар байгалийн баялгаасаа тогтвортой, баталгаатай өгөөж хүртэх боломж нээгдэж байна.

Ийнхүү уг хуулийн төсөл батлагдсанаар Баялгийн санг төрийн өмчийн компаниудаас биш уул уурхайн салбараас бүрдүүлэх зарчим биеллээ олох юм.

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Тусгаар тогтнол үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж заасан байдаг.

Мөн Үндэсний баялгийн сангийн төрөл, түүний эрх зүйн орчныг бүрдүүлэхтэй холбоотойгоор Монгол Улсын Их Хурал 2020 оны 2 дугаар тогтоол, 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, 2020 оны 24 дүгээр тогтоолоор “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2021 оны 12 дугаар тогтоолоор “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” зэргийг тус тус үндэслэн боловсруулсан болно.

Монголчууд баялагийн сангийн зарим төрлүүдээр сан байгуулахаар сүүлийн 20 орчим жилд олонтаа оролдсон боловч өдий хүртэл амжилт олоогүй байна.

2004 оны УИХ-ын сонгуульд “Эх орон-Ардчилал” эвсэл хүүхэд бүртээ баялагийн өгөөжөөс хүртээх зорилго бүхий хүүхдийн мөнгийг олгох амлалтыг дэвшүүлэн оролцож, сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан хамтарсан засгийн үед уг амлалтыг төсвөөр дамжуулан хэрэгжүүлсэн.

2008 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан хамтарсан Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт “Стратегийн томоохон орд газраас олсон орлогоос иргэн бүрд 1.5 сая төгрөг хүртээх эрх зүйн орчин санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж хэрэгжүүлэх”-ээр заасныг УИХ 35 дугаар тогтоолоороо баталгаажуулж өгсөн. Уг зорилтыг хэрэгжүүлэх Хүний хөгжил сангийн тухай хуулийг УИХ 2009 оны 11 сарын 18-ны баталж ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэж, тогтвортой өсөн нэмэгдэх байнгын нөөц бүрдүүлэн иргэддээ тэгш хүртээх зорилгоор хүний хөгжил сан байгуулсан. Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үнэ өндөр үед өөдрөг төсөөллөөр төлөвлөж, уг цаг хугацаанд хангалттай хэмжээний хуримтлал үүсгэж чадаагүй, орлогын тогтвортой урсгалгүй, өгөөж, хуримтлалын тогтолтоогүй бэлэн мөнгийг тараах шийдэл бүхий хэт улс төржсөн урсгал бий болсноор уг сан цаашид оршин тогтнох боломжгүй болсон.

Ийм учраас 2010-2016 онд Хүний хөгжил сангийн алдагдал жил бүр огцом нэмэгдсээр ирсэн тул Хүний хөгжил сангийн тухай хуулийг сайжруулах, уул уурхайн баялагаас орсон орлогыг зохистой зарцуулахаар Ирээдүйн өв сангийн тухай хуулийг 2016 оны 02-р сарын 05-ны өдөр УИХ-аас баталсан. Уг хууль нь эрдэс баялагийн салбарын орлогыг зөвхөн өнөө үеийнхэнд зарцуулахаас гадна ирээдүй хойч үеийнхэндээ тэнцвэртэй хуваарилах зарчмыг санал болгон, хөрөнгө төвлөрүүлэх, хөрөнгө оруулалт хийх замаар өгөөж хүртэх, макро эдийн засгийн тогтвортой, үр ашигтай удирдлагыг хэрэгжүүлэх зорилго бүхий Ирээдүйн өв сан корпорацийг

байгуулахаар зааж өгсөн. Гэвч удалгүй явагдсан УИХ-ын сонгуулийн дүнгээр Засгийн эрх тухайн үеийн сөрөг хүчин, өнөөгийн эрх баригч нарт шилжин улс төржилт, удирдлагын хойрго, хуулийг үл тоосон байдлаас шалтгаалан мөн л одоог хүртэл үр дүнтэйгээр хэрэгжиж чадахгүй байна. 2022 онд тус сангийн хөрөнгөөс хүүхдийн мөнгөн хуримтлалыг санхүүжүүлэхээр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, 2030 он хүртэл гар хүрч болохгүй, 2030 оноос сангийн хөрөнгө оруулалтын цэвэр орлогын 10 хувийг улсын төсөв рүү шилжүүлэх зохицуулалттай уг сангийн хөрөнгийг эрх баригчид төсөв рүү татан дураараа зарцуулж, хуулиар заагдсан корпораци, түүний гүйцэтгэх удирдлагыг өнөөг хүртэл томилолгүйгээр уг хуулийг хэрэгжүүлэлтийг гацааж байна.

Хүний хөгжил санд алдагдал гарч, улсын төсөвт дарамт, алдагдал нь ихсэхтэй зэрэгцэн УИХ-аас 2010 оны 6 сарын 24-ний өдөр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баталсан. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өндөр, төсөв ашигтай байх үед хуримтлуулж, алдагдал нэмэгдэх цагт уг хуримтлалаараа төсвөөрөө тэнцвэржүүлэх зорилго бүхий тогтворжуулалтын сан ч мөн Хүний хөгжил сан, Ирээдүйн өв сан шиг хууль нь хатуу хэрэгжилгүй, өөр зориулалтаар зарцуулагдсаар байгаа тул энэ алдааг залруулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах зохицуулалтыг тусгалаа. Үүнд:

### **Баялгийн сангийн хөрөнгийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, Баялгийн сангийн төрөл**

Баялгийн сангийн сангийн үйл ажиллагаанд хараат бус, бие даасан байх, ил тод, хариуцлагатай байх, үр ашигтай, тогтвортой байх, төсөв, мөнгөний бодлоготой уялдаатай байх, цогц бодлого, нэгдмэл, зохистой удирдлагатай байх, байгалийн баялгийн үр өгөөжийг тэгш, шударга хүртээх, улс төрийн нөлөөллөөс хараат бус байх зарчмыг тусгасан.

Үндэсний баялгийн сангийн үйл ажиллагаа улс төрөөс ангид хараат бус байх зарчим туйлын чухал. Учир манай өнөөгийн эрх баригчид уул уурхайн салбарыг бүхэлд нь төр эзэмшиж байж иргэдэд өгөөжөө өгдөг мэт ойлголтыг суулгаж, улмаар төрийн нэрээр улс төр, эдийн засгийн ашиг сонирхол бүхий бүлэглэлүүд байгалийн баялгийг эзэгнэн нийгэм улам бүр авилгажих үндэс суурь болоод байна. Энэ байдлыг таслан зогоож, иргэдэд нээлттэй, шударга, ил тод байх, хуваарилалт тэгш шударга байх үндсэн зарчмыг баримтлах нь зүйтэй гэж дүгнэж байна.

Баялгийн сан нь газрын хэвлийн баялгаас үүдэлтэй орлогыг урт хугацаанд тогтвортой үр ашигтай удирдах, хөрөнгө оруулалтын өгөөжийг өнөө ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилго Төсвийн тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв сан, Хүртээмжтэй хөгжлийн сан гэсэн бүрэлдэхүүн сангуудтай байна. Энэ хууль батлагдвал Ирээдүй өв сангийн тухай хуулийг хүчингүй болгох юм.

### **Баялгийн сангийн эх үүсвэр, төрөл, зарцуулалт**

Баялгийн сангийн орлого нь татвар ногдуулж, төлүүлэхэд ашиглагдсан гол нэрийн төрлийн эрдэс баялгийн тухайн жилийн төсөвт тооцсон тэнцвэржүүлсэн үнээс өндөр байсны улмаас нэмэгдэж орсон төсвийн орлого, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн өмчид ногдох хувьцааны болон сангийн эзэмших давуу эрхийн хувьцааны ногдол ашиг, хувьцаа борлуулсны орлого, ашигт малтмалын орд газарт

ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн улсын төсөвт ногдох хэсэг болон газрын тос, байгалийн хийн салбарт тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн нөөц ашигласны төлбөр болон бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төрд ногдох хэсгүүдээс бүрдэх юм.

Анхны баялгийн санг 1953 онд газрын тосны орлогын хуримтлалаасаа Кувейт улс үүсгэн байгуулсан байдаг. Үүнээс хойш Сингапурын Темасек холдинг 1974 онд, Арабын Нэгдсэн Эмират улсын Абу Дабигийн баялагийн сан 1976 онд, Сингапурын хөрөнгө оруулалтын корпораци 1981 онд, Норвегийн засгийн газрын тэтгэврийн сан 1990 онд, Австралийн Ирээдүйн сан 2006 онд, Хятадын хөрөнгө оруулалтын корпораци 2007 онд, Бүгд Найрамдах Казакстан Улсын Самрук казына корпоаци 2008 онд байгуулагдсан амжилттай ажиллаж байна.

Харин бид хуулийн төсөлдөө Баялгийн сангаас зөвхөн энэ хуульд заасан үндэслэл, хэмжээгээр:

➤ урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурч төсвийн алдагдал баталсан Дотоодын нийт бүтээгдэхүүний дөрвөн хувиар нэмэгдэж, буурсан тохиолдолд зөвхөн тэнцвэржүүлсэн үнэ болон зах зээлийн үнийн зөрүүгээс үүссэн төсвийн орлогын тасалдал,

➤ төсвийн гол нэр төрлийн эрдэс баялгийн зах зээлийн үнэ төсөвт туссан тэнцвэржүүлсэн үнээс буурсан болон гол нэр төрлийн эрдэс баялгийн экспортын биет хэмжээ төсөвт туссан биет хэмжээнээс 20 хувиар буурсан тохиолдолд зөвхөн тэнцвэржүүлсэн үнэ болон зах зээлийн үнийн зөрүүгээс үүссэн төсвийн орлогын тасалдал,

➤ гамшгийн аюулын хор уршиг, онцгой нөхцөлийн үр дагаврыг арилгахад төсвөөс нэмж шаардагдах санхүүжилтийн тухайн жилийн Дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас давсан хэсгийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн санхүүжүүлж болох бөгөөд хамгийн гол нь иргэддээ тэгш, шударгаар хүртээх, хуваарилах нь үндсэн зорилт юм.

Энэ хуулийн төсөлд заасан байгалийн баялгийн өгөөжийг жил бүр хуваарилах бөгөөд хэрэв иргэн тухайн жилдээ багтаан аваагүй бол дараагийн жилд нэмэгдүүлэн олгох хэдий ч ямар нэг нэмэлт хүү, алданги тооцохгүй тухайн жилд олгохоор тогтоосон үндсэн ногдох өгөөжийг олгоно. Иргэн хэрэв нас барсан, Монгол Улсын иргэний харъяаллаас татгалзсан бол дээр дурдсан өгөөжийг олгохгүй байхаар тооцоолсон.

### **Баялгийн сангийн талаарх төрийн байгууллагуудын эрх, үүрэг**

Улсын Их Хурал Баялгийн сангийн удирдах зөвлөлийг томилох, ажиллах журмыг батлах бөгөөд Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын мандат (цаашид "мандат" гэх)-ыг батлах, хэрэгжилтийг хяналт тавьж төсөв, төсвийн гүйцэтгэлийг нь хэлэлцэж батлах юм. Баялгийн санг байгуулах, татан буулгах, сангийн хөрөнгийг улсын төсөвт эргэн төвлөрүүлэх шийдвэрийг гагцхүү Улсын Их Хурал гаргахаар тусгав.

Засгийн газар Баялгийн сан болон түүний бүрэлдэхүүн санд энэхүү хуулийн дагуу газрын хэвлийн баялгийн орлогыг хуульд заасан хугацаанд төвлөрүүлэх, Баялгийн сангийн Удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгон шалгаруулж, Улсын Их Хуралд танилцуулах, жилийн төсвийн төслийг боловсруулж Улсын Их



Хуралд өргөн мэдүүлэх, Баялгийн сангийн төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хуралд тайлагнах асуудлыг хариуцах юм.

**Төв банк /Монголбанк/** Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын мандатын төслийг боловсруулж, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэн Улсын Их хуралд өргөн мэдүүлэх, Баялгийн сангийн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгон шалгаруулж, Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.

### **Баялгийн сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, түүнийг томилох**

Эрдэс баялгийн орлогыг сонгуулиас сонгуулийн хооронд улс төрчдийн үзэмжээр зарцуулдаг явдлыг таслан зогсоож Үндэсний баялгийн санг жинхэнэ утгаар нь байгуулан Монгол Улсын урт хугацааны эдийн засгийн хөгжил, хүн амын хангалуун амьдралын баталгаа болгох ёстой. Үүний тулд Баялгийн санг хараат бусаар, тогтвортой ажиллуулах хууль эрхзүйн үндэслэл тавигдаж байгаа.

Удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус бүр 1 хүнийг, эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн хараат бус олон нийтийн төлөөлөл 5 хүний нэрийг тус тус дэвшүүлж, Улсын Их Хурал томилно.

Хараат бус гишүүдийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр иргэний нийгмийн байгууллага, санхүү, хөрөнгө оруулалтын салбарын мэргэжилтнүүдээс 5 жилийн хугацаатайгаар сонгоно.

Удирдах зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо нууц санал хураалтаар гишүүдийн олонхын саналаар 5 жилийн хугацаатайгаар сонгоно.

### **Үндэсний баялгийн сангийн корпораци, түүний үйл ажиллагаа**

Нөхөн сэргэдэггүй байгалийн нөөц баялагтай улс орны өмнө боломж ба сорилт тулгардаг. Хэрвээ зөв ашиглавал эдгээр баялаг нь одоо болон ирээдүй үеийнхэнд хөгжил, цэцэглэлт авчирна, харин буруу ашиглах буюу үрэн таран хийвэл эдийн засгийн тогтворгүй байдал, нийгмийн зөрчилдөөн, хүрээлэн буй орчны үргэлжилсэн доройтолд хүргэж болно. Байгалийн баялаг нь дахин сэргэдэггүй баялагт хамаарах тул ашиглах тусам баялгийн хэмжээ багасна.

Иймээс баялгийг ашиглах цаг хугацаанд үр өгөөж нь түүнтэй адил эсхүл түүнээс илүү байх ёстой. Монгол Улс нь байгалийн баялагт түшиглэсэн эдийн засаг бүхий улсын хувьд баялгаа урт хугацааны хөгжлийн бодлого, улсын онцлог, нийгмийн тулгамдсан асуудал зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзэж ард түмэндээ тэгш, шударга хүртээх суурь зарчмыг баримтлах юм.

Байгалийн баялгаас олсон орлогыг хуримтлуулан, тодорхой зорилгоор зарцуулалт, хуваарилалт хийхийн тулд сангийн хөрөнгийг арвижуулах төсөл, хөтөлбөр санхүүжүүлэхэд зарцуулах хууль эрхзүйн үндэс тавигдана.

Байгалийн баялгийг оновчтой зөв удирдах, тэгш хуваарилах, эдийн засгийн уналт, өсөлтөөс урьдчилан сэргийлэх хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд дэлхийн улс орнууд үндэсний баялгийн санг тэр дундаа түүний нэг төрөл болох хөгжлийн санг байгуулах нь зөв гэж сонгосон.

Баялгийн сангийн удирдлага, үйл ажиллагааг энэ хуулийн дагуу байгуулагдах Корпораци хэрэгжүүлнэ. Корпорацийг үүсгэн байгуулах, татан буулгах шийдвэрийг Засгийн газар гаргаж, Улсын Их Хуралд танилцуулна.

Корпораци хөрөнгө оруулалтын, эрсдэлийн удирдлагын, дотоод хяналтын асуудал хариуцсан дотоод бүтцийн нэгжтэй байна. Хороодын даргыг хороодын гишүүдийн олонхын саналаар хоёр жилийн хугацаагаар сонгоно. Хороод нь Удирдах зөвлөлийг мэдээллээр хангах, мэдээлэл боловсруулах, урьдчилсан дүгнэлт, зөвлөмж гаргаж Удирдах зөвлөлд танилцуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### **Баялгийн сангийн тайлагнал, ил тод байдал, хяналт**

Баялгийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг улирал, бүтэн жилээр гаргахдаа Баялгийн сангийн эрсдэлийн удирдлагын тайлан, аудитын дүгнэлтыг заавал гаргана.

Баялгийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны улирлын тайланг дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор Удирдах зөвлөлд хүргүүлнэ. Удирдах зөвлөл Баялгийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны улирлын тайланг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор Монгол Улсын Ерөнхий аудитор хүргүүлж олон нийтэд мэдээлнэ.

Баялгийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж аудит хийлгэсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор Удирдах зөвлөлд хүргүүлнэ.

Удирдах зөвлөл Баялгийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор дүгнэлт гаргаж, аудитын дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд танилцуулна.

Баялгийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаанд олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар доор дурдсан тохиолдолд жил бүр нэгээс доошгүй удаа хийнэ.

Удирдах зөвлөл аудитын байгууллагыг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр сонгож, гэрээ байгуулан ажиллуулна.

### **Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр хуулийн төсөлд тусгасан.

Тусгаар тогтнол Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомжтой нийцэж байгаа болно. Хуулийн төсөлтэй холбогдуулан Ирээдүй өв сангийн тухай хуулийг хүчингүй болгож, Төвбанк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг төслүүдийг дагалдуулан боловсруулсан.

Тусгаар тогтнол Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох тандан судалгаа, үр нөлөө болон зардлын тооцооны судалгааг хавсаргав.

## **ХУУЛЬ САНААЧЛАГЧ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ...дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

### ТУСГААР ТОГТНОЛ ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилго нь эрдэс баялгийн салбарын орлогоос хуримтлал үүсгэж, тогтвортой өсөн нэмэгдэх байнгын нөөц бүрдүүлэн урт хугацааны тогтвортой хөгжлийг тэтгэсэн эдийн засгийн бүтцийг бий болгох, үр өгөөжийг нь одоо ба ирээдүйн иргэддээ тэгш, шударга хүртээх зорилго бүхий Тусгаар тогтнол Үндэсний баялгийн сан /цаашид "Баялгийн сан" гэнэ/-г байгуулах, хөрөнгө төвлөрүүлэх, Баялгийн сангийн хөрөнгийг удирдах, зарцуулах, үйл ажиллагааг тайлагнах болон хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хууль тогтоомж

2.1. Үндэсний баялгийн сангийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Татварын хууль, Шилэн дансны тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Хуульд өөрөөр заагаагүй бол Баялгийн сантай холбогдсон харилцаанд энэ хууль үйлчилнэ.

3.2. Баялгийн сангийн үйл ажиллагаа, хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ хуулиар, энэ хуулиар зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол улсын холбогдох хууль, тогтоомжуудаар зохицуулна.

##### 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "Үндэсний баялгийн сан корпораци" /цаашид "Корпораци" гэх/ гэж Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагыг мандатаар олгогдсон эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх үүрэг бүхий 100 хувь төрийн өмчит хуулийн этгээдийг;

4.1.2. "хөрөнгө оруулалтын хэрэгсэл" гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.6 ба 4.1.8-д заасныг болон энэ хуулиар хориглоогүй хөрөнгө оруулж болох бусад хэлбэрийг;

4.1.3. "Баялгийн сангийн хөрөнгө" гэж Баялгийн сангийн эзэмшил, өмчлөлд байгаа эдийн болон эдийн бус бүх хөрөнгийг;

4.1.4. "Баялгийн сангийн хөрөнгийн удирдлага" гэж Баялгийн сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах, хадгалах, тэдгээрийг арилжаалах, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд ногдох хүү болон ногдол ашгийг хүлээн авах, хөрөнгө оруулалтын хэрэгслийн өмлөгчийн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг;

4.1.5. "Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын мандат" /цаашид "мандат" гэх/ гэж энэ хуульд заасан шаардлагын дагуу Улсын Их Хурлаас баталсан Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх олгосон бодлогын баримт бичгийг;

4.1.6. "хөрөнгө оруулалтын стратеги" гэж мандатын хэрэгжилтийг хангах зорилгоор удирдах зөвлөлөөс баталсан Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаанд баримтлах стратегийн баримт бичгийг;

4.1.7. "Баялгийн сангийн хөрөнгө оруулалтын орлого" гэж Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын үр дүнд бий болсон хүү, ногдол ашиг, түрээсийн орлого, хөрөнгө оруулсан хэрэгслийг борлуулсны ашиг зэрэг Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааны санхүүгийн үр дүнг;

4.1.8. "хөрөнгө оруулалтын менежментийн компани" гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.33-т заасан этгээдийг;

4.1.9. "санхүүгийн үүсмэл хэрэгсэл" гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.7-д заасныг;

4.1.10. "Бүрэлдэхүүн сан" гэж Ирээдүйн өв сан, Төсвийн тогтворжуулалтын сан, Хүртээмжтэй хөгжлийн санг;

## **5 дугаар зүйл. Баялгийн сангийн хөрөнгийн үйл ажиллагаанд баримтлах зарчим**

5.1. Баялгийн сангийн сангийн үйл ажиллагаанд дараах нийтлэг зарчмыг баримтална:

5.1.1. хараат бус, бие даасан байх;

5.1.2. ил тод, хариуцлагатай байх;

5.1.3. үр ашигтай, тогтвортой байх;

5.1.4. төсөв, мөнгөний бодлоготой уялдаатай байх;

5.1.5. цогц бодлого, нэгдмэл, зохистой удирдлагатай байх;

5.1.6. байгалийн баялгийн үр өгөөжийг тэгш, шударга хүртээх;

5.1.7. улс төрийн нөлөөллөөс хараат бус байх;

## **5 дугаар зүйл. Баялгийн сангийн төрөл**

6.1. Баялгийн сан нь газрын хэвлийн баялгаас үүдэлтэй орлогыг урт хугацаанд тогтвортой үр ашигтай удирдах, хөрөнгө оруулалтын өгөөжийг өнөө ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилго бүхий дараах бүрэлдэхүүн сангуудтай байна.

6.1.1. Төсвийн тогтворжуулалтын сан;

6.1.2. Ирээдүйн өв сан;

6.1.3. Хүртээмжтэй хөгжлийн сан;

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ БАЯЛГИЙН САНГИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨРӨЛ, ЗАРЦУУЛАЛТ,**

### **7 дүгээр зүйл. Баялгийн сангийн эх үүсвэр**

7.1. Баялгийн сангийн орлого дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

7.1.1. татвар ногдуулж, төлүүлэхэд ашиглагдсан гол нэрийн төрлийн эрдэс баялгийн тухайн жилийн төсөвт тооцсон тэнцвэржүүлсэн үнээс өндөр байсны улмаас нэмэгдэж орсон төсвийн орлого;

7.1.2. стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн өмчид ногдох хувьцааны болон сангийн эзэмших давуу эрхийн хувьцааны ногдол ашиг, хувьцаа борлуулсны орлого;

7.1.3. ашигт малтмалын орд газарт ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн улсын төсөвт ногдох хэсэг;

7.1.4. газрын тос, байгалийн хийн салбарт тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн нөөц ашигласны төлбөр болон бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төрд ногдох хэсэг;

7.2. Баялгийн санг бүрдүүлэх эх үүсвэрийг татан төвлөрүүлэх журмыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

### **8 дугаар зүйл. Баялгийн сангийн бүрэлдэхүүн сангуудын эх үүсвэр**

8.1. Төсвийн тогтворжуулалтын сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

8.1.1. татвар ногдуулж, төлүүлэхэд ашиглагдсан гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ тухайн жилийн төсөвт тооцсон тэнцвэржүүлсэн үнээс өндөр байсны улмаас нэмэгдэж орсон төсвийн орлого;

8.1.2. төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ашиг;

8.1.3. Засгийн газрын нөөц сангийн болон эрсдэлийн сангийн тухайн төсвийн жилийн зарцуулагдаагүй үлдэгдэл;

8.1.4. Төсвийн тогтворжуулалтын сангийн санхүүгийн үйл ажиллагааны цэвэр орлого;

8.1.5. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар төсвийн тогтворжуулалтын санд хуваарилахаар тогтоосон бусад орлого;

8.2. Ирээдүйн өв сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

8.2.1. ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон төрийн өмчит үйлдвэрийн газрын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг (Хүртээмжтэй хөгжлийн сан эзэмших давуу эрхийн хувьцааны ногдол ашгийн дараах);

8.2.2. ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилаад үлдэх хэсгийн 70 хувь;

8.2.3. Баялгийн сангийн хөрөнгө оруулалтын цэвэр орлогоос энэ хуульд заасны дагуу Тэтгэврийн нөөц сан эсвэл төсөвт шилжүүлсний дараа Баялгийн сангийн үлдэх хэсэг;



8.2.4. Монгол Улсын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, шинээр хууль батлах замаар татвар бий болгох, татварын хувь, хэмжээг өөрчилсөн тохиолдолд эрдэс баялгийн салбарт ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдээс улсын төсөвт орох нэмэлт орлогын 50 хувь;

8.2.5. газрын тос, байгалийн хийн салбарт ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн төлсөн нөөц ашигласны төлбөр болон бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төрд ногдох орлого;

8.2.6. эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийг хувьчлах буюу төрд ногдох эзэмшлийн тодорхой хувийг худалдан борлуулснаас орох орлогын 50%;

### **8.3. Хүртээмжтэй хөгжлийн санд дараах орлогыг төвлөрүүлнэ:**

8.3.1. ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудад эзэмших Баялгийн сангийн давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг;

8.3.2. Эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийг хувьчлах буюу төрд ногдох эзэмшлийн тодорхой хувийг худалдан борлуулснаас орох орлогын 50%;

8.4. Сангийн яам Баялгийн сангийн бүрэлдэхүүн санд ногдох орлогыг төсөвт төвлөрсөн өдрөөс хойш 14 хоногийн дотор шилжүүлнэ.

### **9 дүгээр зүйл. Баялгийн сангийн хөрөнгө зарцуулах, хувь хүртээх**

9.1. Баялгийн сангаас зөвхөн энэ хуульд заасан үндэслэл, хэмжээгээр хөрөнгө зарцуулж болно.

9.2. Тогтворжуулалтын сангийн хөрөнгөөс доор дурдсан санхүүжилт хийх зориулалтаар улсын төсөвт шилжүүлж болно:

9.2.1. урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурч төсвийн алдагдал баталсан Дотоодын нийт бүтээгдэхүүний дөрвөн хувиар нэмэгдэж, буурсан тохиолдолд зөвхөн тэнцвэржүүлсэн үнэ болон зах зээлийн үнийн зөрүүгээс үүссэн төсвийн орлогын тасалдлыг;

9.2.2. төсвийн гол нэр төрлийн эрдэс баялгийн зах зээлийн үнэ төсөвт туссан тэнцвэржүүлсэн үнээс буурсан болон гол нэр төрлийн эрдэс баялгийн экспортын биет хэмжээ төсөвт туссан биет хэмжээнээс 20 хувиар буурсан тохиолдолд зөвхөн тэнцвэржүүлсэн үнэ болон зах зээлийн үнийн зөрүүгээс үүссэн төсвийн орлогын тасалдлыг;

9.2.3. гамшгийн аюулын хор уршиг, онцгой нөхцөлийн үр дагаврыг арилгахад төсвөөс нэмж шаардагдах санхүүжилтийн тухайн жилийн Дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас давсан хэсгийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн санхүүжүүлэх;

9.3. Ирээдүйн өв сангаас дор дурдсан үндэслэлээр хөрөнгө зарцуулж болно:

9.3.1. 2050 он хүртэл хугацаанд Ирээдүйн өв сангийн хөрөнгө оруулалтын цэвэр орлогыг Тэтгэврийн нөөц санд бүрдүүлж дахин хөрөнгө оруулах замаар Тэтгэврийн даатгалын сан дахь шимтгэл төлөгч иргэдийн нэрийн дансыг мөнгөжүүлэх;

9.3.2. 2050 оноос эхлэн Баялгийн сангийн хөрөнгө оруулалтын цэвэр орлогын 10 хувийг улсын төсөвт шилжүүлэх;

9.4. Хүртээмжтэй хөгжлийн сангаас дор дурдсан үндэслэлээр хөрөнгө зарцуулж болно:

9.4.1. Тус сангийн орлогын 50 хувийг жил бүр Монгол Улсын, иргэний харьяаллын зөрчилгүй иргэн бүрд үндэсний баялгийн үр өгөөжийг олгож, өрхийн санхүүгийн чадавхыг дэмжихэд зарцуулах;

9.5. Баялгийн сан, бүрэлдэхүүн сангууд бүхэлдээ нэг менежменттэй байх бөгөөд Баялгийн сангийн үйл ажиллагааны зардлыг нийт сангуудаас тэнцүү хувь хэмжээгээр хувааж санхүүжүүлнэ.

9.6. Баялгийн санд төвлөрүүлэх эх үүсвэр, зарцуулалтын хэмжээг тооцох аргачлал болон уг санд эх үүсвэр төвлөрүүлэх, түүнээс зарцуулалт хийх журмыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.

9.7. Иргэн нас барсан, Монгол Улсын харьяатаас гарсан тохиолдолд үндэсний баялгийн үр өгөөжийг хүртэх эрх дуусгавар болно.

9.8. Иргэн энэ хуульд заасан үр өгөөжийг тухайн жилдээ багтаан аваагүй бол дараагийн жилд нэмэгдүүлэн олгох бөгөөд энэ тохиолдолд хүү тооцохгүй, тухайн жилд ногдох үндсэн өгөөжийг хүртэнэ.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ БАЯЛГИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА**

### **10 дугаар зүйл. Баялгийн сангийн хөрөнгийн удирдлага**

10.1. Баялгийн сангийн үйл ажиллагааны удирдлагыг Корпораци хэрэгжүүлнэ.

10.2. Корпораци энэ хуульд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

### **11 дүгээр зүйл. Хөрөнгө оруулалтын мандат**

11.1. Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааг зөвхөн мандатад заасны дагуу хэрэгжүүлнэ.

11.2. Мандатыг Монгол Улсын Санхүүгийн Тогтвортой Байдлын зөвлөл боловсруулан санал болгож Улсын Их Хурлын тогтоолоор батална.

11.3. Мандатад дараах зүйлсийг тусгана:

11.3.1. бүрэлдэхүүн сан тус бүрийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны дунд, урт хугацааны зорилго;

11.3.2. хөрөнгө оруулалтын төрөл, хугацаа;

11.3.3. хөрөнгө оруулалтын зорилтод нийцүүлэн хүлээж болох эрсдэлийн дээд хязгаар;

11.3.4. ашиглаж болох, мөн хориглох хөрөнгө оруулалтын хэрэгслүүд;

11.3.5. хариуцлагатай хөрөнгө оруулалтад баримтлах байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) шалгуурууд;

11.3.6. Баялгийн сангийн хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцох аргачлал;

11.3.7. хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалт, хяналт, үнэлгээний үйл ажиллагааны процедур, хэм хэмжээ;

11.3.8. тайлагнал, хариуцан тайлагнах болон ил тод байдлын стандарт;

11.4. Мандатаар нэгж хөрөнгө оруулах хэрэгсэл, хуулийн этгээд, эдийн засгийн үйл ажиллагааг нэр зааж хөрөнгө оруулалт хийхэд шууд болон шууд бусаар зааварчилгаа өгөхийг хориглоно.

11.5. Мандат зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нөхцөл байдал үүссэн тухай бүрд Удирдах зөвлөл хууль, журамд заагдсан арга хэмжээ авах буюу Улсын Их Хуралд нэн даруй мэдээлнэ.

11.6. Мандатын хэрэгжилтийг сангийн үйл ажиллагааны тайлангийн хамт жил бүр Улсын Их Хуралд танилцуулна.

## **12 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын стратеги**

12.1. Бүрэлдэхүүн сан тус бүрийн хөрөнгө оруулалтын стратегийг Удирдах зөвлөлөөс баталж Гүйцэтгэх удирдлага, Хөрөнгө оруулалтын менежментийн компани хэрэгжүүлнэ.

12.2. Хөрөнгө оруулалтын стратегид дараах зүйлсийг тусгана:

12.2.1. эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх дээд түвшин;

12.2.2. өгөөжийн зорилтот түвшин;

12.2.3. хөрвөх чадварын шалгуур үзүүлэлт;

12.2.4. хөрөнгө оруулалтын хэрэгсэл тус бүрд байршуулах хөрөнгийн хувь хэмжээний дээд хязгаар;

12.2.5. хөрөнгө оруулалтын сонголт хийх шалгуур, үнэт цаасны зэрэглэл, зээлжих чадавхын шаардлага;

12.2.6. хөрөнгө оруулах газар зүйн байршил, эдийн засгийн салбарууд болон тэдгээрт тавигдах хязгаарлалт;

12.2.7. хөрөнгө оруулах зах зээл, валютын төрөл;

12.2.8. хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг үнэлэхэд ашиглах олон улсын жишиг (бэнчмарк) индекс эсвэл индикатор;

12.2.9. Удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад зүйл;

12.3. Стратегийн хэрэгжилтэд Удирдах зөвлөл түүний дэргэдэх Аудитын хороогоор дамжуулан байнгын хяналт тавьж ажиллана.

## **13 дугаар зүйл. Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаанд тавигдах шаардлага**

13.1. Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаанд дараах шаардлага тавигдана:

13.1.1.Зээл авах болон санхүүгийн хөшүүрэг оролцсон аливаа төрлийн гэрээ, хэлцэл хийхгүй байх;

13.1.2.Баялгийн сангийн хөрөнгийг барьцаалах, зээл олгох, зээлийн баталгаа, батлан даалт гаргах болон бусад аливаа хэлбэрээр бусдын үүргийн гүйцэтгэлийг хангах гэрээ, хэлцэл байгуулахгүй байх;

13.1.3.Санхүүгийн үүсмэл хэрэгслийг зөвхөн хөрөнгө оруулалтын эрсдэлийг хаах, бууруулах зорилгоор ашиглах;

13.1.4.Баялгийн сангийн хөрөнгийг дор дурдсанаас бусад тохиолдолд зөвхөн олон улсын санхүүгийн зах зээлд гаргасан гадаад улсын нутаг дэвсгэрт нээлттэй зах зээлд арилжаалагдаж байгаа хөрөнгө оруулах хэрэгсэлд байршуулах;

13.1.5.Зөвхөн Хүртээмжтэй хөгжлийн сангаас Монгол Улсын эдийн засгийн уул уурхайн салбараас хамаарах хамаарлыг бууруулж төрөлжүүлэн хөгжүүлэх, дотоодын санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих зорилгоор дотоодын зах зээлд хөрөнгө оруулж болох бөгөөд уг хөрөнгө оруулалтын хэмжээ нь иргэдэд газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг хуваарилсны дараах тус сангийн удирдаж буй нийт хөрөнгийн 50 хувиас хэтрэхгүй байх;

13.1.6.Баялгийн сангаас энэ хуулийн 13.1.5 дахь заалтад дурдсан дотоод хөрөнгө оруулалт хийх тохиолдолд зөвхөн Монгол Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаасанд хөрөнгө оруулах;

13.1.7.Баялгийн сангаас энэ хуулийн 13.1.5 дахь заалтад дурдсан дотоодын хөрөнгө оруулалт хийхдээ уул уурхайн салбарын үнэт цаасанд хөрөнгө оруулахыг хориглох;

13.1.8.Нэгж санхүүгийн хэрэгсэлд байршуулсан хөрөнгийн хувь, хэмжээг хөрөнгө оруулж байгаа этгээдийн хяналтын багцын хувь, хэмжээнд хүргэхгүй байх;

13.1.9.Татан төвлөрүүлсэн хөрөнгө нь Монгол Улсад шууд орох, Монгол Улсын төлбөрийн тэнцлийн орох урсгалд бүртгэгдэх хөрөнгө оруулах хэрэгсэл болон бусад Монгол Улсад бүртгэлтэй хөрөнгө оруулах санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахгүй байх;

13.2.Баялгийн сангийн хөрөнгийг энэхүү хуульд заасан бүрэлдэхүүн сангийн зориулалтаас өөрөөр зарцуулахыг хориглоно.

13.3.Баялгийн сангийн хөрөнгөөс дараах хэлбэрээр хөрөнгө оруулахыг хориглоно:

13.3.1.цэрэг, зэвсэг, хар тамхи, мансууруулах бодис, тамхи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, тэдгээрийн худалдаа, хуулиар хориглосон бусад үйл ажиллагаанд;

13.3.2.эрх бүхий этгээдэд бүртгүүлээгүй үнэт цаасанд;

13.3.3.Нэгдсэн Үндэсний байгууллагад хоригтой орны Засгийн газар болон компанийн хувьцаа, бонд, санхүүгийн хэрэгсэлд;

13.3.4.дайн, зэвсэгт мөргөлдөөн бүхий бүс нутаг, түүний Засгийн газар болон компанийн хувьцаа, бондод;

13.3.5.Мандатад заасан хөрөнгө оруулалтын хүрээ, төрөлд заагаагүй бусад үнэт цаас, хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд;

13.3.6.авто зам, төмөр зам, нисэх буудал болон хот байгуулалтын тухай хуулийн 3.1.10-т заасан инженерийн дэд бүтцэд хамаарах үл хөдлөх эд хөрөнгөд;

## **14 дугаар зүйл. Баялгийн сангийн хөрөнгө оруулалтын менежмент**

14.1. Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагыг хориос доошгүй жилийн туршлагатай, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хувийн Хөрөнгө оруулалтын менежментийн компани эсвэл хэд хэдэн компаниудыг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулж, гүйцэтгүүлнэ.

14.2. Баялгийн сангийн үйл ажиллагааны нөөц чадавхыг бүрдүүлэх шилжилтийн хугацаанд (3 хүртэл жил) Сангийн хөрөнгийг Олон улсын хөгжлийн байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааг гүйцэтгүүлж болно.

14.3. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн гүйцэтгэлийг Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл жил бүр дүгнэж, шаардлагатай тохиолдолд солих буюу дахин сонгон шалгаруулж болно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ КОРПОРАЦИ, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **15 дугаар зүйл. Корпораци**

15.1. Баялгийн сангийн удирдлага, үйл ажиллагааг энэ хуулийн дагуу байгуулагдах Корпораци хэрэгжүүлнэ.

15.2. Корпорацийг үүсгэн байгуулах, татан буулгах шийдвэрийг Засгийн газар гаргаж, Улсын Их Хуралд танилцуулна.

15.3. Корпораци үйл ажиллагаандаа болон хөрөнгө оруулах шийдвэрийг мандат, хөрөнгө оруулалтын стратегийн хүрээнд гаргахдаа бусад байгууллага, албан тушаалтнаас хараат бусаар, бие даасан, олон нийтэд ил тод, албан тушаалтан, хувь хүн, улс төрийн намын эрх ашигт хөтлөгдөхгүй байх үндсэн зарчмыг баримтална.

15.4. Корпораци Монголбанкинд төгрөгийн болон валютын харилцах данстай байна.

15.5. Корпорацийн Монголбанк дахь төгрөг болон гадаад валютын дансны хооронд хийх гүйлгээг Монголбанкнаас зарласан тухайн өдрийн албан ханшаар Монголбанк гүйцэтгэнэ.

15.6. Корпораци хөрөнгө оруулалтын, эрсдэлийн удирдлагын, дотоод хяналтын асуудал хариуцсан дотоод бүтцийн нэгжтэй байна.

15.7. Хороодын даргыг хороодын гишүүдийн олонхын саналаар хоёр жилийн хугацаагаар сонгоно.

15.8. Хороод нь Удирдах зөвлөлийг мэдээллээр хангах, мэдээлэл боловсруулах, урьдчилсан дүгнэлт, зөвлөмж гаргаж Удирдах зөвлөлд танилцуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

15.9. Корпорацийн дүрмийг энэ хуульд нийцүүлэн Засгийн газар батална.

15.10. Корпорацийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана:



15.10.1. корпорацийн бүрэн болон товчилсон оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ, Корпорацийн үйл ажиллагааны чиглэл;

15.10.2. корпорацийн хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;

15.10.3. Удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын энэ хуулиар тодорхойлсноос бусад бүрэн эрх;

15.10.4. Корпорацийн дүрэмд тусгахаар хуульд заасан бусад зүйл;

15.11. Корпорацийн дүрэмд хууль тогтоомжтой зөрчилдөөгүй бусад зүйлийг тусгаж болно.

## **16 дугаар зүйл. Корпорацийн гүйцэтгэх удирдлага**

16.1. Корпорацийн гүйцэтгэх удирдлагыг /цаашид "гүйцэтгэх удирдлага" гэх/ хувь хүн, эсхүл багаар хэрэгжүүлнэ.

16.2. Гүйцэтгэх удирдлагыг хувь хүн, эсхүл багаар хэрэгжүүлэх шийдвэрийг удирдах зөвлөл гаргана.

16.3. Гүйцэтгэх удирдлага нь Корпорацийн дүрэм болон удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна.

16.4. Гэрээнд гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэргийг заавал тусгасан байна.

16.5. Гүйцэтгэх удирдлага нь Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, Корпорацийг төлөөлөх зэргээр Корпорацийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

16.6. Гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэх тохиолдолд Корпорацийн дүрэм болон Удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор багийн гишүүдийн ажиллах дотоод журмыг Удирдах зөвлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр баталж мөрдөнө.

16.7. Энэ хуулийн 16.6-д заасан баг Удирдах зөвлөлийн өмнө гэрээ болон Корпорацийн дүрэм, холбогдох хууль тогтоомжийн дагуу хамтын хариуцлага хүлээнэ.

16.8. Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч баг энэ хуулийн 16.5-д заасны дагуу гэрээ, хэлцэл хийх, төлөөллийг хэрэгжүүлэх тохиолдолд Корпорацийг төлөөлж багийн ахлагч гарын үсэг зурна.

16.9. Энэ хуулийн 16.8-д заасан багийн ахлагчийг Удирдах зөвлөлтэй зөвшилцөн багийн гишүүд сонгох бөгөөд багийн ахлагч Корпорацийн гүйцэтгэх захирлын үүргийг гүйцэтгэнэ.

16.10. Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг Удирдах зөвлөл хэдийд ч гаргах эрхтэй.

16.11. Хувь хүн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байгаа тохиолдолд уг этгээд Корпорацийн гүйцэтгэх захирал байна.

16.12. Гүйцэтгэх удирдлагын үндсэн эрх, үүргийг энэ хууль, Корпорацийн дүрэм болон Удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээгээр нарийвчлан тодорхойлно.

16.13. Гүйцэтгэх удирдлага дараах шаардлагыг хангасан байна:

16.13.1. эдийн засаг, санхүү, үнэт цаасны аль нэг чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх;

16.13.2. зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн өргүй байх;

16.13.3. хувь хүний ёс зүй болон нэр хүнд нь Корпорацийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх;

16.13.4. ял шийтгэлгүй байх;

16.13.5. санхүү, хөрөнгө оруулах үйл ажиллагаанд шийдвэр гаргах түвшинд 10-аас доошгүй жил, санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан байх;

16.13.6. Удирдах зөвлөлийн үндэслэл бүхий, шаардлагатай гэж үзсэн бусад;

16.14. Гүйцэтгэх удирдлагаар дараах этгээдийг томилохыг хориглоно:

16.14.1. төрийн албаны улс төрийн албан тушаалтан;

16.14.2. улс төрийн намын гишүүн;

16.14.3. Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцогч хуулийн этгээдэд сүүлийн хоёр жилийн хугацаанд ажиллаж байсан, эсхүл ажиллаж байгаа этгээд;

16.15. Гүйцэтгэх удирдлага бусад байгууллагад ажил, албан тушаал хавсран эрхлэхийг хориглоно.

16.16. Гүйцэтгэх удирдлага Баялгийн сангийн хөрөнгийн бүртгэл, хадгалалт, гүйлгээ болон бусад шаардлагатай үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр олон улсын нэр хүнд бүхий кастодианы байгууллагаар гүйцэтгүүлнэ.

16.17. Гүйцэтгэх удирдлага Удирдах зөвлөлийн зөвшөөрөлтэйгөөр Баялгийн сангийн хөрөнгийг гэрээний үндсэн дээр хөндлөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компаниар гүйцэтгүүлж болно.

16.18. Хөндлөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодианы байгууллага болон Корпорацийн хооронд байгуулах гэрээг Удирдах зөвлөлөөс зөвшөөрөл авсны үндсэн дээр гүйцэтгэх удирдлага байгуулна.

## **ТАВДУГААР БҮЛЭГ БАЯЛГИЙН САНГИЙН ЗАСАГЛАЛ**

**17 дугаар зүйл. Баялгийн сан**

17.1. Баялгийн сан нь Монгол Улсын нийт ард түмний өмч байх бөгөөд Засгийн газраар дамжуулж энэхүү өмчлөх эрхээ жил бүр ногдол ашиг хүртэх хэлбэрээр хэрэгжүүлнэ.

17.2. Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын бодлого тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих үүргийн Корпораци хэрэгжүүлнэ.

## **18 дугаар зүйл. Баялгийн сангийн талаар Улсын Их Хурлын бүрэн эрх**

18.1. Улсын Их Хурал Баялгийн сангийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.1.1. Баялгийн сангийн удирдах зөвлөлийг томилох, ажиллах журмыг батлах;

18.1.2. Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын мандат (цаашид "мандат" гэх)-ыг батлах, хэрэгжилтийг хяналт тавих;

18.1.3. Баялгийн сангийн төсвийг хэлэлцэж батлах;

18.1.4. Баялгийн сангийн төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн, батлах;

18.1.5. Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын гүйцэтгэл, үр дүнд хяналт тавих;

18.1.6. Баялгийн санг байгуулах, татан буулгах, сангийн хөрөнгийг улсын төсөвт эргэн төвлөрүүлэх шийдвэрийг гагцхүү Улсын Их Хурал гаргана.

## **19 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх**

19.1. Монгол Улсын Засгийн газар Баялгийн сангийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.1.1. Баялгийн сан болон түүний бүрэлдэхүүн санд энэхүү хуулийн дагуу газрын хэвлийн баялгийн орлогыг хуульд заасан хугацаанд төвлөрүүлэх;

19.1.2. Баялгийн сангийн Удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгон шалгаруулж, Улсын Их Хуралд танилцуулах;

19.1.3. Баялгийн сангийн жилийн төсвийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

19.1.4. Баялгийн сангийн төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хуралд тайлагнах;

## **20 дугаар зүйл . Төв банк /Монголбанк/-ны бүрэн эрх**

20.1. Монгол Улсын Төв банк /Монголбанк/ Баялгийн сангийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

20.1.1. Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын мандатын төслийг боловсруулж, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэн Улсын Их хуралд өргөн мэдүүлэх;

20.1.2. Баялгийн сангийн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгон шалгаруулж, Улсын Их Хуралд танилцуулах;

**21 дугаар зүйл. Баялгийн сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, түүнийг томилох**

21.1. Энэ хуулийн 15.1-д заасан хуулийн этгээд удирдах зөвлөлтэй байх бөгөөд Корпорацийн эрх барих дээд байгууллага байна.

21.2. Удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус бүр 1 хүнийг, эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн хараат бус олон нийтийн төлөөлөл 5 хүний нэрийг тус тус дэвшүүлж, Улсын Их Хурал томилно.

21.3. Хараат бус гишүүдийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр иргэний нийгмийн байгууллага, санхүү, хөрөнгө оруулалтын салбарын мэргэжилтнүүдээс 5 жилийн хугацаатайгаар сонгоно.

21.4. Удирдах зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо нууц санал хураалтаар гишүүдийн олонхын саналаар 5 жилийн хугацаатайгаар сонгоно.

## **22 дугаар зүйл. Удирдах зөвлөлийн чиг үүрэг**

22.1. Удирдах зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

22.1.1. Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын мандат (хөрөнгө оруулалтын бодлого)-ыг хэрэгжилтийг хангуулах;

22.1.2. Баялгийн сангийн хөрөнгө оруулалтын стратегийг боловсруулж, батлах, хэрэгжилтийг хангуулах;

22.1.3. хуулийн дагуу сангуудаас улсын төсөвт хөрөнгө шилжүүлэх зөвшөөрлийг олгох;

22.1.4. Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагыг зохистой, эрсдэл багатай байлгах зорилгоор хууль болон Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын мандат, стратегийн хүрээнд нарийвчилсан бодлого, эрсдэлийн хязгаарлалт, журмуудыг боловсруулж, мөрдүүлэх;

22.1.5. Баялгийн сангийн үйл ажиллагаа болон Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын гүйцэтгэл, үр дүн болон тайлагналд хяналт тавих;

22.1.6. Баялгийн сангийн санхүү болон үйл ажиллагаанд хяналт тавих хөндлөнгийн аудиторыг сонгох;

22.1.7. Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын менежментийн компанийг сонгон шалгаруулах, өөрчлөх, гэрээг дуусгавар болгох;

22.2. Удирдах зөвлөл улирал бүр нэгээс доошгүй удаа хуралдана.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ БАЯЛГИЙН САНГИЙН ТАЙЛАГНАЛ, ИЛ ТОД БАЙДАЛ, ХЯНАЛТ**

### **23 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэл**

23.1. Хөрөнгө оруулалтын менежментийн компани өөрийн хөрөнгө болон Баялгийн сангийн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийг тусгаарлан бүртгэнэ.

## **24 дүгээр зүйл. Баялгийн сангийн тайлан**

24.1. Баялгийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг улирал, бүтэн жилээр гаргана.

24.2. Баялгийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны улирлын тайланд дараах зүйлийг тусгана:

- 24.2.1. Корпорацийн санхүүгийн тайлан;
- 24.2.2. Баялгийн сангийн санхүүгийн тайлан;
- 24.2.3. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн тайлан;
- 24.2.4. Хөрөнгө оруулалтын мандат, стратегийн хэрэгжилт;
- 24.2.5. Удирдах зөвлөлөөс тогтоосон нарийвчилсан бодлого, зохицуулалт, журмуудын хэрэгжилт;
- 24.2.6. Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн;
- 24.2.7. Хөрөнгө оруулалтын менежментийн компани тус бүрийн Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн;
- 24.2.8. Баялгийн сангийн хөрөнгийг байршуулсан хөрөнгө оруулалтын төрөл, ангилал, хөрөнгө оруулалтын задаргаа, тус бүрийн бодит болон хэрэгжээгүй өгөөж, алдагдал;

24.3. Баялгийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланд дараах зүйлийг тусгана:

- 24.3.1. энэ хуулийн 29.2-т заасан улирлын тайланд тусгасан зүйлс;
- 24.3.2. Баялгийн сангийн эрсдэлийн удирдлагын тайлан;
- 24.3.3. аудитын дүгнэлт;

24.4. Баялгийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны улирлын тайланг дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор Удирдах зөвлөлд хүргүүлнэ.

24.5. Удирдах зөвлөл Баялгийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны улирлын тайланг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор Монгол Улсын Ерөнхий аудитор хүргүүлж олон нийтэд мэдээлнэ.

24.6. Баялгийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж аудит хийлгэсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор Удирдах зөвлөлд хүргүүлнэ.

24.7. Удирдах зөвлөл Баялгийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор дүгнэлт гаргаж, аудитын дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд танилцуулна.

## **25 дугаар зүйл. Хөндлөнгийн аудит**

25.1. Баялгийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаанд олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар доор дурдсан тохиолдолд аудит хийлгэнэ:



- 25.1.1. Жил бүр нэгээс доошгүй удаа;
- 25.1.2. Удирдах зөвлөл мандатын хэрэгжилтийг хангалтгүй гэж дүгнэсэн тохиолдолд.
- 25.1.3. Удирдах зөвлөл аудитын байгууллагыг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр сонгож, гэрээ байгуулан ажиллуулна.

## **ДОЛООДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **26 дугаар зүйл. Хариуцлага хүлээлгэх үндэслэл**

26.1. Баялгийн сангийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хуульд заасан хариуцлага оногдуулсан нь түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

### **27 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

27.1. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

27.2. Баялгийн сангийн тухай хууль зөрчигчид торгууль оногдуулсан нь тухайн зөрчлийг арилгах, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

### **28 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

28.1. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2023 оны ...дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй.

**1/ 27<sup>2</sup> дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5/ дахь заалт:**

“5/ Тусгаар тогтнол Үндэсний Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын мандатын төслийг боловсруулан хэлэлцүүлэх;”

**2 дугаар зүйл.** Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27<sup>2</sup> дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5/ дахь заалтын дугаарлалтын “6/” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Тусгаар тогтнол Үндэсний баялгийн сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2023 оны ...дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** 2016 оын 2 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан Ирээдүй өв сангийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Тусгаар тогтнол Үндэсний баялгийн сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## **ҮНДЭСНИЙ БАЯЛАГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН СУДАЛГАА**

### **НЭГ. Ерөнхий мэдээлэл**

2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд "Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ." гэж тодорхойгоор зааж өгсөн. Үүнд нийцүүлэн Үндэсний баялагийн сангийн тухай хуулиа батлан хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

### **ХОЁР. АСУУДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

#### **Мөн чанар, цар хүрээг тогтоох**

Монголчууд баялагийн сангийн зарим төрлүүдээр сан байгуулахаар сүүлийн 20 орчим жилд олонтаа оролдсон боловч өдий хүртэл амжилт олоогүй байна.

2004 оны УИХ-ын сонгуульд "Эх орон-Ардчилал" эвсэл хүүхэд бүртээ баялагийн өгөөжөөс хүртээх зорилго бүхий хүүхдийн мөнгийг олгох амлалтыг дэвшүүлэн оролцож, сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан хамтарсан засгийн үед уг амлалтыг төсвөөр дамжуулан хэрэгжүүлсэн.

2008 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан хамтарсан Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт "Стратегийн томоохон орд газраас олсон орлогоос иргэн бүрд 1.5 сая төгрөг хүртээх эрх зүйн орчин санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж хэрэгжүүлэх"-ээр заасныг УИХ 35 дугаар тогтоолоороо баталгаажуулж өгсөн. Уг зорилтыг хэрэгжүүлэх Хүний хөгжил сангийн тухай хуулийг УИХ 2009 оны 11 сарын 18-ны баталж ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэж, тогтвортой өсөн нэмэгдэх байнгын нөөц бүрдүүлэн иргэддээ тэгш хүртээх зорилгоор хүний хөгжил сан байгуулсан. Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үнэ өндөр үед өөдрөг төсөөллөөр төлөвлөж, уг цаг хугацаанд хангалттай хэмжээний хуримтлал үүсгэж чадаагүй, орлогын тогтвортой урсгалгүй, өгөөж, хуримтлалын тогтолцоогүй бэлэн мөнгийг тараах шийдэл бүхий хэт улс төржсөн урсгал бий болсноор уг сан цаашид оршин тогтнох боломжгүй болсон.

Ийм учраас 2010-2016 онд Хүний хөгжил сангийн алдагдал жил бүр огцом нэмэгдсээр ирсэн тул Хүний хөгжил сангийн тухай хуулийг сайжруулах, уул уурхайн баялагаас орсон орлогыг зохистой зарцуулахаар Ирээдүйн өв сангийн тухай хуулийг 2016 оны 02-р сарын 05-ны өдөр УИХ-аас баталсан. Уг хууль нь эрдэс баялагийн салбарын орлогыг зөвхөн өнөө үеийнхэнд зарцуулахаас гадна ирээдүй хойч үеийнхэндээ тэнцвэртэй хуваарилах зарчмыг санал болгон, хөрөнгө төвлөрүүлэх, хөрөнгө оруулалт хийх замаар өгөөж хүртэх, макро эдийн засгийн тогтвортой, үр ашигтай удирдлагыг хэрэгжүүлэх зорилго бүхий Ирээдүйн өв сан корпорацийг байгуулахаар зааж өгсөн. Гэвч удалгүй явагдсан УИХ-ын сонгуулийн дүнгээр Засгийн эрх тухайн үеийн сөрөг хүчин, өнөөгийн эрх баригч нарт шилжин улс төржилт, удирдлагын хойрго, хуулийг үл тоосон байдлаас шалтгаалан мөн л одоог хүртэл үр дүнтэйгээр хэрэгжиж чадахгүй байна. 2022

онд тус сангийн хөрөнгөөс хүүхдийн мөнгөн хуримтлалыг санхүүжүүлэхээр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, 2030 он хүртэл гар хүрч болохгүй, 2030 оноос сангийн хөрөнгө оруулалтын цэвэр орлогын 10 хувийг улсын төсөв рүү шилжүүлэх зохицуулалттай уг сангийн хөрөнгийг эрх баригчид төсөв рүү татан дураараа зарцуулж, хуулиар заагдсан корпораци, түүний гүйцэтгэх удирдлагыг өнөөг хүртэл томилолгүйгээр уг хуулийг хэрэгжүүлэлтийг гацааж байна.

Хүний хөгжил санд алдагдал гарч, улсын төсөвт дарамт, алдагдал нь ихсэхтэй зэрэгцэн УИХ-аас 2010 оны 6 сарын 24-ний өдөр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баталсан. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өндөр, төсөв ашигтай байх үед хуримтлуулж, алдагдал нэмэгдэх цагт уг хуримтлалаараа төсвөөрөө тэнцвэржүүлэх зорилго бүхий тогтворжуулалтын сан ч мөн Хүний хөгжил сан, Ирээдүйн өв сан шиг хууль нь хатуу хэрэгжилгүй, өөр зориулалтаар зарцуулагдсаар байна.

**Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох**

Уг зохицуулалттай холбоотойгоор дараах бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын эрх ашиг хөндөгдөж байна гэж үзэж байна.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
Бизнес эрхлэгчид	Газрын баялагийн үр өгөөжийг эдийн засгаа төрөлжүүлэн хөгжүүлэх чиглэлд зарцуулах, төрөлжилтийг дэмжих
Иргэд	Баялагийн сангаас өгөөж хүртэх
Төрийн байгууллага	Иргэдээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвийн баялагийн үр өгөөжийг тэгш, шударга хуваарилах

#### **Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөл**

Монголчууд бид сүүлийн 20 орчим жилийн хугацаанд газрын баялаг, түүнээс орж буй орлогоо өнөө ба ирээдүйн иргэдэд тэгш хүртээх, хуваарилах Хүний хөгжил сангийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг тус тус батлан хэрэгжүүлсэн ч хүссэн үр дүндээ хүрээгүй байгаа нь нэгэнт тодорхой байна.

Энэ нь:

1. Улс төржилт, улс төр-засаглалын тогтворгүй хуулийг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх нийгмийн зөвшилцөлгүй байдал
2. Сангийн орлого, түүнийг зохистойгоор удирдах, зарцуулах тогтолцоогүй байдал
3. Сонгууль угтан иргэдэд шууд бэлэн мөнгө тараах улс төрийн шийдвэрийг олонтаа гаргасан байдал байна хэмээн ерөнхийлөн дүгнэж болохоор байна.

УИХ-аас баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д “Баялгийн сан байгуулж, санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийнэ.” гэж,

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” “Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ.”, “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлж, уул уурхайгаас олох үр шимийг Баялгийн сангаар дамжуулан иргэн бүрд тэгш, шударга хүртээх тогтолцоог бүрдүүлнэ.” гэж зааж өгсөн.

## **ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

Баялагийн сангийн зорилгоо ахин шинээр харж, хуулийн зохицуулалтыг илүү нарийвчлан, улс төржилтөөс хамаарсан хамаарлыг бууруулж, олон улсын жишигт нийцүүлэх бодит шаардлага байна гэж үзэж байна.

## **ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛ ДЭЭР ХИЙСЭН ХАРЬЦУУЛАЛТ**

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-т заасан зохицуулалтын хувилбаруудын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг нь харьцууллаа.

“Тэг” хувилбар буюу зохицуулалт хийхээс татгалзах” буюу одоогийн байгаагаар орхиж болно. Гэвч өрсөлдөөн ширүүсч, дэлхий улам бүр хавтгайрч, нэг тэнхлэг дээр уялдан, өрсөлдөж амьдарч буй шинэ дэг журамд тун тохиромжгүй хувилбар юм. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн дагуу үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ хангалтгүй, төрөөс тодорхой зохицуулалт хийх зайлшгүй шаардлагатай байгаа учир энэ хувилбарыг сонгох боломжгүй.

“Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх” хувилбарын хувьд иргэд, олон нийт, бизнесүүдэд түрэн ирж буй чиг хандлагын талаарх мэдээллийг хангалттай сайн өгөх боловч түүнд тохирсон түүхий эд, өгөгдлийн баазыг төр нийлүүлэхгүй тул ашиглагдах боломжгүй хувилбар.

“Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх” хувилбарын хувьд татвар, хураамжийн бодлого, зөвшөөрөл, лиценз, квотыг тогтоох замаар зохицуулдаг хувилбар. Төр өөрт буй мэдээллийг хуримтлуулан хүргэх, өгөх үйлчилгээ үзүүлж буй тул өөрийн төлбөр хураамжтай байна. Үүнийг хэн, хэрхэн тогтоох зарчмыг заавал судлах ёстой болж байна.

“Төрөөс санхүүгийн интервенц хийх” -тохиромжгүй хувилбар.

“Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх” боломжтой боловч анхдагч буюу задгай өгөгдөл нь хувь хүний болон байгууллага, төрийн албаны нууцад хамаарах мэдээлэлтэй тул тохиромжгүй хувилбар.

“Захиргааны шийдвэр гаргах”-Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлд заасан захиргааны акт хэлбэрээр шийдвэрлэхэд тохиромжгүй гэж үзсэн тул сонгох боломжгүй.

Иймээс “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” гэсэн хувилбарыг сонголоо. Иймд тохирох хуульд нэмэлт оруулах замаар дараах асуудлуудыг шийдвэрлэх боломжтой тул “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбарыг сонгов.

## ТАВ. СОНГОСОН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Сонгосон хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн хууль тус бүрээр гаргалаа.

Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүл эх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар	
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1 Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх		Үгүй	
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм		
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх		Үгүй	
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн	Тийм		



	Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх			
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Үгүй	
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх		Үгүй	
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	
3.Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм		
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Үгүй	
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх		Үгүй	
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/		Үгүй	
4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		
5.Жендэрийн эрх тэгш байдлыг	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		

хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		
-------------------------------------	---	------	--	--

Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх нөлөө	Үр	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар		1.1 Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх үү?	Үгүй	
		1.2 Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх /эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан/?	Үгүй	
		1.3 Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах уу?	Үгүй	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал		2.1 Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах уу?	Үгүй	
		2.2 Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох уу?	Үгүй	
		2.3 Зах зээлд шинээр орж ирж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэлийг бий болгох уу?	Үгүй	
		2.4 Зах зээлд шинээр монополийг бий болгох уу?	Үгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн		3.1 Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн	Үгүй	

болон захиргааны зардал	нэгжид шинээр зардал үүсэх эсэх			
	3.2 Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	3.3 Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	
	3.4 Бараа, бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	
	3.5 Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч буй захиргааны зардлын ачаалал	4.1 Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардлуудыг /Жишээ нь, мэдээлэх, тайлан гаргах гэх мэт/ бий болгох эсэх		Үгүй	
5.Өмчлөх эрх	5.1 Өмчлөх эрхийг /үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг/ хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	
	5.2 Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	
	5.3 Оюуны өмчийн /патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг/ эрхийг зөрчсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	
6.Инноваци ба судалгаа шинжилгээ	6.1 Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх		Үгүй	

	6.2 Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		Үгүй	
7.Хэрэглэгч ба гэр бүлийн төсөв	7.1 Хэрэглээний үнийн төвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	7.2 Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	
	7.3 Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.4 Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд, мөн урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1 Тодорхой бүс нутгуудад тодорхой нэг чиглэлд, ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Үгүй	
	8.2 Тодорхой бүс нутгуудад тодорхой чиглэлд, ажлын байрыг багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	8.3 Жижиг, дунд үйлдвэрүүд, эсхүл аж ахуйн нэгжийн тодорхой салбаруудад онцгой нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
9.Төрийн захиргааны байгууллага	9.1 Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	9.2 Шинээр төрийн байгууллага байгуулах, эсвэл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдэх шаардлага тавигдах эсэх		Үгүй	
	9.3 Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	

10.Микро эдийн засгийн хүрээнд	10.1 Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	10.2 Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм		
	10.3 Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	
11.Олон улсын харилцаа	11.1 Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		

Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1 Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй	
	1.2 Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	
	1.3 Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	1.4 Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1 Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй	
	2.2 Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	2.3 Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	

	2.4 Шинээр ажлын стандарт гаргаж ирэх эсэх		Үгүй	
	2.5 Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлтийг бий болгох эсэх		Үгүй	
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1 Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	
	3.2 Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүйчүүдэд, үндэстний цөөнхөд г.м		Үгүй	
	3.3 Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1 Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.2 Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм		
	4.3 Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм		
	4.4 Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.5 Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
	5.1 Хувь хүний/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	

5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.2 Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эс эх		Үгүй	
	5.3 Хүмүүсийн амьдралын хэв маяг /хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ/- т нөлөөлөх эсэх		Үгүй	
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1 Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм		
	6.2 Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	
	6.3 Иргэдийн боловсрол /төрийн болон хувийн хэвшлийн сургуулиар/ олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	6.4 Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	6.5 Их дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1 Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.2 Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.3 Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөөлөх эсэх		Үгүй	



	7.4 Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
8.Соёл	8.1 Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	8.2 Хэл соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	8.3 Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	

Хүснэгт 5.

Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх нөлөө	Үр	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1.Агаар		1.1 Зохицуулалтын үр дүнд агаар бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
2.Зам тээвэр, түлш эрчим хүч		2.1 Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/ бууруулах эсэх	Үгүй	
		2.2 Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
		2.3 Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
		2.4 Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
3.Ан амьтан, ургамал хамгаалах		3.1 Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Үгүй	
		3.2 Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	
		3.3 Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	

	3.4 Тусгай хамгаалалттай газар нутагт сэргээр нөлөөлөх эсэх		Үгүй	
4.Усны нөөц	4.1 Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сэргээр нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.2 Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
	4.3 Ундны усны чанарт нөлөөлөх эсэх		Үгүй	
5.Хөрсний бохирдол	5.1 Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	5.2 Хөрсийг эвдлэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
6.Газрын ашиглалт	6.1 Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		Үгүй	
	6.2 Газрын зохицуулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	
	6.3 Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	
7.Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй баялаг	7.1 Самар, жимс зэрэг нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг түүний нөхөн сэргээлтийн хугацаанаас өмнө ашиглах эсэх		Үгүй	
	7.2 Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		Үгүй	

### **ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ**

Иймээс аргачлалын 7-д зааснаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонгосон.

Хувилбаруудын эерэг болон сөрөг тал, зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцаа, хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, хууль тогтоомжтой нийцэж буй эсэх, гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж, хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой гэж дүгнэлээ.

## **ДОЛОО. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Анхны баялгийн санг 1953 онд газрын тосны орлогын хуримтлалаасаа Кувейт улс үүсгэн байгуулсан байдаг. Үүнээс хойш Сингапурын Темасек холдинг 1974 онд, Арабын Нэгдсэн Эмират улсын Абу Дабигийн баялагийн сан 1976 онд, Сингапурын хөрөнгө оруулалтын корпораци 1981 онд, Норвегийн засгийн газрын тэтгэврийн сан 1990 онд, Австралийн Ирээдүйн сан 2006 онд, Хятадын хөрөнгө оруулалтын корпораци 2007 онд, Бүгд Найрамдах Казакстан Улсын Самрук казына корпоаци 2008 онд байгуулагдсан амжилттай ажиллаж байна.




UAE INTERNATIONAL  
INVESTORS COUNCIL

#uaeicc

# THE 10 LARGEST

sovereign wealth funds worldwide



Source: SOVEREIGN WEALTH FUND INSTITUTE (SWFI)

f @ in   
www.uaeicc.ae

#COVID19

Үндэсний баялгийн санг түүний зорилго, үйл ажиллагааг нь шалгуур болгож дараах төрөлд ангилж болно:

- Тогтворжуулалтын сан
- Хуримтлалын сан
- Тэтгэврийн сан
- Хөрөнгө оруулалтын сан;
- Баялагийн сан гэж ерөнхийлөн ангилдаг.

Тухайн улс орнууд өөрсдийн шийдвэрлэх асуудал, тэргүүлэх зорилтоос хамааран баялагийн сан нь эдгээр сангуудын аль нэг нь буюу хэд хэдэн багтсан дэд сангуудтай байх нь нийтлэг.

Дэлхийд алдартай том зарим сангийн менежер, орлого, эзэмшлийн талаарх тойм харьцуулалтыг хавсаргав.

Сангийн нэр	Огноо	Сангийн менежер	Орлого	Эзэмшигч
НОРВЕГИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭТГЭВРИЙН САН (THE GOVERNMENT PENSION FUND)	1990	Засгийн газрын тэтгэврийн сан (глобал)- Norges Bank Investment Management;	Засгийн газрын нэгдсэн төсвөөс шилжүүлсэн газрын тосны мөнгөн орлого;	Норвегийн Сангийн яам
		Засгийн газрын тэтгэврийн сан-Норвеги Folketrygdfond et	Газрын тосны үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн гүйлгээний үр ашиг болон Сангийн хөрөнгийн үр өгөөж	
БНХАУ-ЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН КОРПОРАЦИ (CHINA INVESTMENT CORPORATION)	2007	Гадаад дах хөрөнгө оруулалтыг CIC International Co., Ltd (CIC International) ба CIC Capital Corporation (CIC Capital),	Хөрөнгө оруулалтын орлого	БНХАУ-ын Төрийн зөвлөл
		Хятадын төрийн өмчит компаниудад хийх хөрөнгө оруулалтыг Central Huijin Investment Ltd. (Central Huijin)		
СИНГАПУР УЛСЫН ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН	1981	Дотоодод хийх хөрөнгө оруулалт - Темасек холдинг	Хөрөнгө оруулалтын орлого	Сангийн яам

		(Temasek Holdings)		
		Гадаадад хийх хөрөнгө оруулалт- Сингапурын ЗГ-ын хөрөнгө оруулалтын корпораци		
БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН "САМРУК- КАЗЫНА" ХК (SAMRUK- KAZYNA JSC)	2008	Төрийн өмчит компани хэлбэртэй	Ногдол ашиг	Казакстаны Засгийн газар

### НАЙМ. ЗӨВЛӨМЖ

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг зохих журмын дагуу хийж гүйцэтгэхэд нэгэнт батлагдсан хуулийг хэлбэрэлтгүй, улс төржилгүйгээр хэрэгжүүлэх, хэрэв түүнд алдаа, хийдэл байх аваас нэн яаралтай засаж сайжруулж явах нь юу юунаас илүү чухал нь харагдаж байна.

## ТУСГААР ТОГТНОЛ ҮНДЭСНИЙ БАЯЛАГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг Үндэсний баялагийн сангийн тухай хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Үндэсний баялагийн сангийн тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар бүлэгт заасны дагуу "Улсын Их Хурлын тогтоол" хэлбэрээр боловсруулагдсан.

Хуулийн төслүүдийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал"-д /цаашид "Аргачлал" гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

### ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо.

Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Харилцан уялдаа зэрэг болно.

#### Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

"Зорилгод хүрэх байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж байгаа байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой байдлаар томъёологдсон эсэхийг үнэллээ. Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан болно.



“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалтууд тэдгээрийг дагаж мөрдөх болон хэрэгжүүлэх этгээдэд тухайн хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг үнэлэхээр сонгосон болно.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдэд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь бүхэлд нь Монгол Улсын Үндсэн Хууль, холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг Аргачлалд заасан асуултад хариулах замаар үнэлгээг хийхээр тооцов.

### **ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилгыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 4 <sup>1.2</sup> дүгээр зүйл	Хуулийн төслийн сонгосон зүйлүүд практикт хэрэгжих боломжтой эсэхийг холбогдох хуулийн зохицуулалт хоорондын уялдаа, хэрэгжилтийн практик, мэргэжилтнүүдийн санал, дүгнэлтэд тулгуурлан дүн шинжилгээ хийнэ.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

### **“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

1992 оны шинэ Үндсэн хууль, түүнд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Үндсэн хуулийн 6.2-д заасны дагуу “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ...” гэж заасны дагуу уг хуулийн төслийг боловсруулсан билээ.

### **“Ойлгомжтой” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу тогтоолын төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага</b>	
<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</b>	<b>Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал</b>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлагад нийцсэн
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлагад нийцсэн
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлагад нийцсэн
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлагад нийцсэн

29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлагад нийцсэн
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлагад нийцсэн
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлагад нийцсэн
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлагад нийцсэн
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлагад нийцсэн
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Шаардлагад нийцсэн
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлагад нийцсэн
<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага</b>	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлагад нийцсэн
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлагад нийцсэн
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлагад нийцсэн
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлагад нийцсэн

30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.

Шаардлагад нийцсэн

**“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай тогтоллын төслийн зүйл заалтуудыг үзэхэд уялдаа, хамаарлыг сайтар тодорхойлж өгч чадсан гэж үзэж байна.

№	Асуулт	Хариулт
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Нийцсэн
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Нийцсэн
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Нийцсэн
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцсэн
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Давхардаагүй
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тусгасан
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Орхигдуулаагүй
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Тусгаагүй
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Боломжтой
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Үгүй

12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Тусгаагүй
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Ийм зохицуулалт шаардлагагүй
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Ийм зохицуулалт шаардлагагүй
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Ийм зохицуулалт шаардлагагүй
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Ийм зохицуулалт шаардлагагүй

### ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Энэхүү үнэлгээг Үндэсний баялагийн сангийн тухай хуулийн төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал"-ын дагуу тооцож дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна.

Энэхүү үнэлгээг эдгээр хуулийн төслүүдэд хийхэд сонгосон шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэхэд хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг хангасан, практикт хэрэгжих бүрэн боломжтой, хуулийн төслийн томъёолол нь ойлгомжтой, хоёрдмол утга санаагүй, тодорхой, Монгол Улсын үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон тухайн хуулийн зүйл, заалттай давхардаагүй, зөрчилдөөгүй гэж дүгнэж байна.

Иймд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын дагуу Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, хуулийн төслийн уялдаа холбоо хангагдсан байна гэж үзлээ.

## **ТУСГААР ТОГТНОЛ ҮНДЭСНИЙ БАЯЛАГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Үндэсний баялагийн сангийн тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Тусгагдсан зохицуулалттай уялдан зардал үүсгэх болон үүсгэж болзошгүй зүйл, заалтыг Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу судлалаа.

### **ХОЁР. ҮНДЭСНИЙ БАЯЛАГИЙН САНГИЙН ТУХАЙ**

**Хууль батлагдсанаар иргэнд үүсэх зардлын талаар:** Хуулийн төслөөр иргэдэд шинээр үүрэг гүйцэтгэхийг даалгаагүй байх тул зардал үүсгэх зохицуулалт байхгүй байна. Харин ч хууль батлагдан хэрэгжснээр иргэд, ирээдүй хойчийн эдийн засгийн баталгаа хангагдах болно.

Шинээр татвар, зөвшөөрөл, нэмэлт бүртгэлийн асуудал үүсэхгүй тул аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй гэж үзлээ.

### **ГУРАВ. ҮНДЭСНИЙ БАЯЛАГИЙН САНГИЙН ТУХАЙ**

**Хууль батлагдсанаар хуулийн этгээдэд үүсэх зардлын талаар:** Хуулийн төслөөр хуулийн этгээдүүдэд шинээр үүрэг гүйцэтгэхийг даалгаагүй байх тул зардал үүсгэх зохицуулалт байхгүй байна.

Иймд аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй бөгөөд Үндэсний баялагийн сангийн тухай хууль нь хууль этгээд, аж ахуйн нэгжүүдэд нэмэлт зардал үүсгэхгүй гэж үзлээ.

### **ДӨРӨВ. ҮНДЭСНИЙ БАЯЛАГИЙН САНГИЙН ТУХАЙ**

**Хууль батлагдсанаар төрд үүсэх зардлын талаар:** Хууль төсөл хэрэгжиж эхэлснээр шинээр татвар, чиг үүрэг төрд шинээр бий болохгүй.

**“ТУСГААР ТОГТНОЛ” ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛЖ БУЙТАЙ ХОЛБООТОЙ ОЛОН НИЙТИЙН  
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛУУД**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д заасан заалтыг хэрэгжүүлсэн байдал:

1. 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдөр “Тусгаар тогтнол” Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөлд Эдийн засагчид болон холбогдох салбарын төлөөлөлтэй уулзаж санал авав.
2. 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдөр “Монгол Улсын эрдэс баялгийн салбарын бодлого, үндэсний баялгийн сан” хэлэлцүүлгийг Төрийн ордон, Их эзэн чингис хаан танхимд 100 орчим хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулав.
3. 2023 оны 09 дүгээр сарын 06-ний өдөр “Тусгаар тогтнол” Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөлд Эдийн засгийн сэтгүүлч, шинжээчдийн клубын гишүүдэд танилцуулах, санал авах хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Хэлэлцүүлгийн үед өгсөн саналууд	Хуулийн төсөлд тусгасан эсэх	Тайлбар
1. Дэлхийн аль ч улс оронд уул уурхайг дагаж их хэмжээний орлого ордог. Түүнийг зарцуулах засаглалын түүх өөр өөр. Ил тод байдал, улс төрийн нөлөөллөөс хол байх зарчмыг баримталсан улсад “Үндэсний баялгийн сан” амжилттай хэрэгжсээр ирсэн байдаг. Үнэнийг л хэлье! Манай улс шиг “Баялгийн сан”-гаараа төсвийн цоорхойгоо нөхөж ирсэн улс орон алга!	Тийм	
2. Баялгийн сангийн удирдлага нь улс төрөөс ангид, хараат бус, мэргэжлийн байх ёстой. Гэвч манай улсын Баялгийн сангийн түүхээс харвал дээрх бүх зарчим үйлчлээгүй явсаар ирлээ. Сангийн удирдлагыг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх эрх зүйн орчныг яаралтай бүрдүүлэх ёстой.	Тийм	
3. Байгалийн нөөц бүхий орнууд авилгалд өртөмтгий, ардчиллын институциудийн хөгжил сул байна. Байгалийн нөөцийн орлого нь төсвийн тогтворгүй байдлын шалтгаан болж, өрсөлдөх	Тийм	

	чадварыг сулруулдаг сөрөг нөлөө үзүүлдэг. Эрдэс баялгийн салбарын бодлого, Үндэсний баялагийн сангийн хуулийг боловсруулахдаа эдгээр сөрөг үр дагаварыг бууруулахад чиглэх ёстой.		
4.	Баялгийн сангийн хөрөнгийг олон улсын зах зээлд байршуулж дотоодын эрсдлээс хамгаалдаг, тэгснээрээ “Голланд өвчин”-с сэргийлдэг нийтлэг жишигтэй. Гэлээ гэхдээ зөвхөн уул уурхайгаас орлого олж буй манайх шиг хөгжиж буй эдийн засгийн хувьд бусад салбараа дэмжих дотоод буюу хөгжлийн хөрөнгө оруулалтыг Баялгийн сангаас тодорхой хэмжээгээр хийх хэрэгтэй.	Тийм	
5.	Манай улсад одоо баялгийн сан байгуулах болоогүй, тийм нөхцөл бүрдээгүй байна. Эхний ээлжинд олсон орлогоороо өрөө дарах, түүний дараа ядаж 10 тэрбум доллартай болж байж Баялгийн сан байгуулъя гэж ярих хэрэгтэй.	Үгүй	Монгол Улсын Үндсэн хуульд байгалийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн сангаар дамжуулан удирдахаар тодорхой заасантай нийцэхгүй.
6.	Баялгийн санг шууд олон улсад нэр хүндтэй хөрөнгө оруулалтын менежментийн компаниудаар удирдуулна гэдэг бол зардалтай. Үүний оронд Дэлхийн банк, ОУВС зэрэг хөгжлийн санхүүгийн байгууллагууд иймэрхүү төрлийн итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлдэг, тэдэнтэй хамтарч ажиллаж болно.	Зарим талаар	Санг үүсгэн байгуулсны дараах шилжилтийн үе буюу 3 хүртэл жилийн хугацаанд олон улсын хөгжлийн санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж болохоор хуульд тусгасан.
7.	Баялгийн сангаас халамж тарааж огт болохгүй. Харин өнөө ба хойч үеийн нийт иргэддээ баялгын эзэн болж түүндээ хяналт тавих боломжийг олгох буюу уул уурхайн төрийн өмчит компаниудад хувьцаа эзэмшдэг болгох шийдэл хэрэгтэй.	Тийм	
8.	Төрийн өмчийн нэг том холдинг компани байгаад тэр нь уул уурхайн төслүүдэд хувь эзэмшдэг, тус компанийн хувьцааг иргэдэд эзэмшүүлдэг байх хувилбарыг манай улс	Тийм	



	<p>туршиж үзээд бүтэлгүйтсэн. Эрдэнэс Монгол компани үүний нэг жишээ. Түүний оронд төрийн өмчийн компаниудыг аль болох цөөлж хувьчлах буюу ХК болгон олон нийтийн эзэмшилтэй болгох нь зөв.</p>		
--	---	--	--





